



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН
САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ

*ЭМД-ын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог үр дүнтэй
хэрэгжүүлж байгаа хэдий ч цаашид засаж сайжруулах шаардлагатай,
хүндрэл бэрхшээлтэй асуудлууд оршиж байна.*

АУДИТЫН КОД: СЭА-2023/19-17-ШТА-ГА



Сүхбаатар сум
2023 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.

Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа

Утас: 70363040, Цахим хаяг:

Enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батмөнх

Утас: 70363036, Цахим хаяг:

Batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Отгонбаяр

Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn

Аудитор Т.Одсүрэн

Цахим хаяг: Odsurent@audit.gov.mn

Аудитор Д.Чулуунцэцэг

Цахим хаяг: Chuluuntsetsegd@audit.gov.mn

Аудитор Б.Наранцэцэг

Цахим хаяг: Narantsetsegba@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа Аудитын менежер Б.Батмөнх Ахлах аудитор Ц.Отгонбаяр Аудитор Т.Одсүрэн Д.Чулуунцэцэг Б.Наранцэцэг Хаяг: Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ-ын байрны өргөтгөлд 2023 оны 05 дугаар сар	АГУУЛГА Товчилсон үгийн тайлбар Хүснэгт, дүрслэл, хавсралтын товьёг АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТОГТОЛЦОО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАГДАЖ БАЙНА УУ? <i>1.1. Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт эрүүл мэндийн даатгалын чанар, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн арга хэмжээ үр дүнтэй байна уу?</i> ХОЁРДУГААР БҮЛЭГ: ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГААС ДААТГУУЛАГЧИЙН ЭРЭЛТ, ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГАД НИЙЦСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧАНАРТАЙ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БАЙНА УУ? <i>2.1. Эрүүл мэндийн даатгалын орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож байна уу?</i> <i>2.2. Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн салбарт тодорхой ахиц дэвшил гарч байна уу?</i> <i>2.3. Эрүүл мэндийн даатгалын салбарын хяналт шалгалт, дотоод аудитын үйл ажиллагаа үр нөлөөтэй байна уу?</i> ДҮГНЭЛТ ЗӨВЛӨМЖ
---	--

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХЧТА	Хөдөлмөрийн чадвар түр алдсан
ЭМБ	Эрүүл мэндийн байгууллага
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Хүснэгтийн товчлол

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Урьдчилан сэргийлэх үзлэгийн багцын төлбөр болон бодит зардлын гүйцэтгэлийн зөрүү	12
Хүснэгт 2	ЭМДС-д 2021-2022 онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	13
Хүснэгт 3	Оношийн хамааралтай бүлгээр сонгон шалгаруулалтад тэнцсэн ЭМБ-уудын мэдээлэл	15
Хүснэгт 4	Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ"-ний гүйцэтгэлээр 2021-2022 онд олгосон санхүүжилт	18
Хүснэгт 5	Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын / төрийн / 2022 оны орлого, зарлагын судалгаа	20
Хүснэгт 6	Аймгийн ЭМБ-уудын 2021, 2022 оны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд	21
Хүснэгт 7	Эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын судалгаа	22
Хүснэгт 8	Эрүүл мэндийн даатгалд шинээр хамруулах ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл	23
Хүснэгт 9	Эрүүл мэндийн даатгалын байгууллагуудад ирүүлсэн өргөдөл, гомдол, шийдвэрлэлт	26
Хүснэгт 10	ЭМБ-уудын 2021-2022 оны гүйцэтгэлийн санхүүжилтийн нэхэмжлэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж олгосон санхүүжилт	29

Хавсралтын товъёг

Д/д	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	ЭМДС-аас 2021 онд олгосон санхүүжилтийн дүн	
Хавсралт 2	ЭМДС-аас 2022 онд олгосон санхүүжилтийн дүн	
Хавсралт 3	ЭМБ-уудын 2022 онд авсан санхүүжилтийн зарцуулалтын судалгаа	

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”- г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх;
- ЭМБ-с даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд, аймгийн болон Мандал сумын нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн 2021-2022 оны үйл ажиллагааг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын

шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

- Эрүүл мэндийн тухай хууль (2011 он);
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (2015 он);
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль (2016 он);
- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль (2016 он);
- “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол);
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай (УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоол);
- “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин” (УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоол);
- Эрүүл мэндийн салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030 он)
- Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2020-2023 оны тогтоолууд;
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын 2020-2023 оны тушаалууд;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Ц.Отгонбаяр, аудитор Т.Одсүрэн, Д.Чулуунцэцэг, Б.Наранцэцэг нар 2023 оны 03 дугаар сарын 15-наас 05 дугаар сарын 19-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

УИХ-аас Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр эрүүл мэндийн даатгалын хууль, эрх зүйн орчин шинэчлэгдэж, иргэд эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдах, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний төлбөрийн тариф, шалгуурыг оновчтой болгох ажлууд хэрэгжиж эхэлсэн байна.

Төрийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг олон улсын эмнэл зүйн удирдамжид үндэслэн оношийн хамааралтай бүлгээр нэхэмжлэх эмчилгээ, үйлчилгээний

тарифыг ЭМДҮЗ-ийн “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2021 оны 03 болон 04 дүгээр тогтоолоор баталсан байна.

Монгол Улсад дараах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэрэгжүүлж байна. Үүнд:

- *Өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ;*
- *Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ;*
- *Эх барихын тусламж, үйлчилгээ;*
- *Яаралтай тусламж үйлчилгээ;*
- *Түргэн тусламжийн үйлчилгээ;*
- *Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээ;*
- *Сэргээн засах тусламж, үйлчилгээ.*

Бүлэг 1

Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдаж байна уу?

Төрөөс баримтлах бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан эрүүл мэндийн даатгал, гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой зорилго, зорилтууд хэрэгжиж эхэлсэн хэдий ч цаашид засаж, сайжруулах шаардлагатай, хүндрэл бэрхшээлтэй асуудлууд оршиж байна.

1.1 Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт эрүүл мэндийн даатгалын чанар, хүртээмжтэй тогтолцоог хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж байна уу?

1.1.1 Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд эрүүл мэндийн даатгалын талаар тусгасан зорилт, арга хэмжээний уялдаа холбоо, хэрэгжилт хангагдаж байна уу?

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д тусгагдсан “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.” гэсэн үндсэн зорилгыг хэрэгжүүлэх 9 зорилт, үүнээс эрүүл мэндийн даатгал, гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой дараах 4 зорилт дэвшүүлж, 2021-2030 онд хүрэх түвшинг тодорхойлсон байна. Үүнд:

- ✓ Нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоотой болсон байна.
- ✓ Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдсэн байна.
- ✓ Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлж, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлж, өвчлөл, нас баралтын эрсдэлт хүчин зүйл буурсан байна.
- ✓ Эрүүл мэндийн үйлчилгээнд даатгалын, улсын төсвийн болон хувь хүний санхүүжилтийн зохистой харьцааг бий болгож, хүн амын эрүүл амьдралын хэвшлийг төлөвшүүлж, иргэн бүрийг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулан, нийт сумыг хамарсан алсын зайн үндэсний сүлжээг бий болгож, хүн амын дундаж наслалт уртассан байна.

Дээрх зорилтууд Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг болон Сэлэнгэ аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нарийвчлан тусгагдсан буюу бодлогын баримт бичиг хоорондын уялдаа холбоо хангагдсан байна.

Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд УИХ-аас Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл мэндийн тухай, Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуульд 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулснаар эрүүл мэндийн даатгалын эрх зүйн орчин шинэчлэгдэж, иргэд эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдах, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний төлбөрийн тариф, шалгуурыг оновчтой болгох ажлууд хэрэгжиж эхэлсэн байна.

2022 оны 12 дугаар сард “Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө” болон “Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2023-2026 оны стратеги төлөвлөгөө”-г Эрүүл мэндийн сайд баталсан байна.

Дээрх урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт, бичгүүдийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2021-2022 онуудад дараах ажлуудыг хийж гүйцэтгэн, тодорхой үр дүнд хүрсэн байна. Үүнд:

✓ *Эмнэлэг дагасан санхүүжилтийн хуучин тогтолцоог өөрчилж, даатгуулагч иргэн, үйлчлүүлэгчээ дагасан санхүүжилтийн тогтолцоо хэрэгжиж эхэлсэн,*

✓ *Иргэдэд үзүүлэх бүх төрлийн тусламж үйлчилгээ, үзлэг, оношилгоог ЭМД-ын хөнгөлөлтөд хамруулах, нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэнээр иргэдээс гарах төлбөрийн хэмжээг бууруулсан байна. Тухайлбал:*

- *Даатгуулагчид эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлснөөр жилд 2 сая төгрөг хүртэлх хөнгөлөлтийг эдэлж, үүнд өндөр өртөгтэй тусламж, үйлчилгээ, хорт хавдрын химийн болон туяаны өдрийн эмчилгээ, урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний зардал хамаарахгүй байхаар зохицуулагдсан байсан бол 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн бүх төрлийн тусламж үйлчилгээг ЭМД-ын хөнгөлөлтөд хамруулахаар болсон,*
- *ЭМД-ын сангаас үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг дээд хязгааргүй болгосон.*
- *Хэвтэн эмчлэх тусламж, үйлчилгээг өвчний хүнд болон хөнгөн зэргээс хамааруулан ялгаатай санхүүжүүлэхээр тооцсон.*

- ✓ *Даатгуулагчид хийсэн оношилгоо, шинжилгээний зардалд улирлын 165.0 мянган төгрөг хүртэл санхүүжилтийг сангаас олгодог байсныг өндөр өртөг бүхий /MRI, CT, дуран, цөмийн оношилгоо, зүрхний эхо гэх мэт/ оношилгоо, шинжилгээний зардлын 70 хувийг сангаас хариуцаж, иргэн 30 хувийг төлөх зохицуулалт хийсэн. Үүний үр дүнд Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2021 онд 683 иргэн 42.4 сая төгрөгийн, 2022 онд 2737 иргэн 242.6 сая төгрөгийн өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээнд хамрагдсан байна.*
- ✓ *Хорт хавдар, харвалт, шигдээс, бөөрний дутагдал, түлэгдэлт, төрөлхийн гажиг, төрөх, эмэгтэйчүүд, халдварт өвчин гэх мэт амь нас аврах нэн шаардлагатай болон иргэдэд санхүүгийн эрсдэл учруулж болох тусламж үйлчилгээний зардлыг бүхэлд нь эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр болсон. Игнэснээр Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2021 онд 3273 иргэн 320.8 сая төгрөгийн, 2022 онд 3208 иргэн 461.8 сая төгрөгийн*

гемодиализын үйлчилгээнд, 2021 онд 29 иргэн 14.2 сая төгрөгийн, 2022 онд 80 иргэн 62.9 сая төгрөгийн хөнгөвчлөх тусламж, үйлчилгээнд хамрагдсан байна.

- ✓ Салбарын ачааллаас хувийн хэвшлийн ЭМБ хуваалцах боломжийг нэмэгдүүлэн сонгон шалгаруулалтад тэнцсэн, даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан хувийн хэвшлийн эмнэлэг санхүүжилт авах боломж бүрдсэн,
- ✓ Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх тусламжийг 2020 оны 11 сараас эхлэн шинэчилсэн журмаар олгох ажлыг хэрэгжүүлснээр иргэд сарын аль ч өдөр цахим эмийн жорыг бүх шатны ЭМБ-ын эмчээр бичүүлж, хүссэн эмийн сангаас хөнгөлөлттэй эмийг чирэгдэлгүй, хүртээмжтэй авч үйлчлүүлдэг болсон байна.

1.1.2 Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл хууль тогтоомж, дүрэмд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж байна уу?

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Эрүүл мэндийн даатгалын удирдах дээд байгууллага нь Үндэсний зөвлөл байна.” гэж заасан бөгөөд 14 дүгээр зүйлийн 14.8, 14.9-д ЭМДҮЗ-ийн эрх, үүргийг тодорхойлсон байдаг.

ЭМДҮЗ нь тус хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.6¹, 14.8.7² дахь заалтуудыг хэрэгжүүлэн 2021-2022 онд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой 8 тогтоолыг баталсан байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах, өрх, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, даатгалын сангаас санхүүжүүлэх журмыг 2021 оны 03, 04 дүгээр тогтоолуудаар шинэчилсэн боловч 2022 оны 01 дүгээр тогтоолоор дахин шинэчлэн баталж, Эрүүл мэндийн даатгалын сангаас худалдан авах “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын журам”, нэр томьёоны тайлбар, хяналтын үйл явцын зураглал, нэхэмжлэлийн хяналтын шалгуурыг 05, 12 дугаар тогтоолуудаар баталсан байна.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, гүйцэтгэлд тулгуурласан санхүүжилт, даатгалын тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн актууд нь тогтворгүй, жилд 2-3 удаа шинэчлэгдэж байгаа нь гүйцэтгэлийн тогтолцоонд шилжих үеийн хүндрэл, хяналтын сул талыг түргэн шуурхай шийдвэрлэж, сайжруулж байгаа сайн талтай боловч эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн, эдийн засгийн үр ашиг, гүйцэтгэлийн тогтолцооны үр нөлөөг бодитоор тооцоход хүндрэл үүсгэж байна.

¹ 14.8.6.эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох журам, тогтоол, зөвлөмж гаргах;

² “даатгалын гэрээний дагуу худалдан авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг олон улсын эмнэл зүйн удирдамж ашиглан батлах”

Иймд бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн хүрсэн байх зорилтод түвшинг бодитоор тооцож үйл ажиллагааны үр дүн, эдийн засгийн үр ашиг, гүйцэтгэлийн тогтолцооны үр нөлөөг сайжруулахын тулд эрх зүйн актыг үндэслэлтэй сайн боловсруулж, тогтвортой байдлыг хангах, тайлант жилийн дундуур өөрчлөлт оруулахгүй байх, шинээр батлан гаргасан эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож байх нь зүйтэй юм.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан *“Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж үйлчилгээг санхүүжүүлэх төлбөрийн арга”-ын 3.1-д “Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний суурь тарифын хэмжээг дараах нөхцөлийн аль нэг бүрдсэн үед заавал шинэчилнэ. 3.1.1: Албан ёсны статистикаар жилийн инфляцын сүүлийн 2 жилийн нийлбэр 10 хувиас давсан, 3.1.2: Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн сүлжээг шинэчилсэн, ... “ гэж заасан байна.*

Гэтэл албан ёсны статистик мэдээгээр 2022 оны инфляци 13.2 хувьд хүрч, Засгийн Газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар *“Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ”-г шинэчлэн тогтоосон атал өнөөг хүртэл эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний суурь тарифын хэмжээг шинэчлэн тогтоогүй байна.*

1.1.3 Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог үр дүнтэй, олон улсын жишгийн дагуу зохион байгуулж байна уу?

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд ЭМДЕГ нь эрүүл мэндийн байгууллагаас худалдан авч буй тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих, чанарыг сайжруулахын тулд төслийн багаар нийгмийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоотой улс орнууд болох БНСУ, Тайван, Эстони зэрэг улсын сайн туршлагыг өөрийн орны онцлогт тохируулж боловсруулан ЭМДҮЗ-ийн 2021 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 05 дугаар тогтоолоор *“Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын журам”-ыг батлуулсан байна.*

УИХ-ын 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.8.7-д *“Даатгалын гэрээний дагуу худалдан авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлэх журмыг олон улсын эмнэл зүйн удирдамж ашиглан батлах,”* гэсэн заалт нэмж тусгагдсанаар үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог олон улсын жишгийн дагуу зохион байгуулах нөхцөл хангагдсан байна.

Энэ журам нь анагаах ухааны нотолгоонд суурилсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эмнэл зүйн удирдамжид үндэслэн боловсруулагдсан, нийт 230 оношийн хүрээнд эмнэл зүйн үйл явцыг үнэлэх шалгууртай бөгөөд энэ нь эмч мэргэжилтнүүдийн нотолгоонд суурилсан шийдвэр гаргах үйл явцыг дэмжих,

тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чухал ач холбогдолтой болсон байна.

Бид аудитын явцад лавлагаа шатны 2 улсын эмнэлэг, 2 хувийн эмнэлэг, сум, тосгоны 18 ЭМТ, 5 өрхийн ЭМТ-өөс үзүүлж буй тусламж, үйлчилгээ, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж үзэхэд дээр дурдсан давуу талуудаас гадна дараах хүндрэл бэрхшээлүүд тулгарч байна. Үүнд:

- Шинэ тогтолцоонд шилжих бэлтгэл бүрэн хангагдаагүй, эрүүл мэндийн байгууллагууд тэгш бус гараанаас эхэлснээс хүний нөөцийн болон техник тоног төхөөрөмжийн хангалт харилцан адилгүй, зарим төрлийн оношийн хамааралтай бүлгийн сонгон шалгаруулалтад оролцох нөхцөл бүрдээгүй,
- Лавлагаа шатны улсын эмнэлгүүдэд нарийн мэргэжлийн эмч дутагдалтайгаас үзлэгийн цаг хүлээлт ихтэй, иргэдэд чирэгдэл учруулж байна. Тухайлбал, аймгийн нэгдсэн эмнэлгийн цахим бүртгэлийн тасгийн мэдээ, тайлангаас түүвэр хийж үзэхэд шүдний эмчийн цаг сарын эхний 5 хоногт дуусдаг, зүрх судас, мэдрэлийн тасгийн цаг 10-15 хоногийн хүлээлттэй, сарын дунд гэхэд тухайн сарын цаг дуусдаг гэх мэт.
- Дутагдалтай байгаа ажлын байрыг нийтэд нээлттэй зарладаг хэдий ч цалин хөлс бага, нийгмийн асуудлыг шийдвэрлэх боломж байхгүйгээс тогтвор суурьшилтай ажиллах боловсон хүчин ирдээгүй.
- Эрүүл мэндийн салбарын ажилчдад үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжихтэй холбоотой сургалт хангалтгүй зохион байгуулагдсан, энэ талын мэдлэг, ойлголт сул байсан, ЭМДҮЗ, ЭМДЕГ-ын шийдвэрээр батлагдсан журмуудыг мөрдөж эхлэхийн өмнө бус дараа нь сургалт хийгддэг, компьютер, техник хэрэгслүүдийн хүчин чадал хангалтгүй, алслагдсан сумдын интернэтийн хурд удаан зэргээс шалтгаалан программ хангамжид мэдээллийг дутуу оруулж, санхүүжилт хасагддаг,
- Нийгмийн эрүүл мэнд буюу урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилт, энэ талын ажил хангалтгүйгээс өвчин хүндэрсэн үедээ оношилогдож, эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардал өсдөг,
- Эрчимт эмчилгээний улаан эрэмбийн А, яаралтай тусламжийн ногоон, шар эрэмбийн А зэрэглэлийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг төрөлжсөн эмнэлгүүдэд олгохоор хязгаарласнаас амь тэмцсэн зайлшгүй шаардлагатай үед уг тусламж, үйлчилгээг үзүүлээд санхүүжилт нэхэмжлэх эрх үүсдэггүй, эсвэл санхүүжилтээ авахын тулд эрэмбэ бууруулж оношилбол өвчтөний биеийн байдлыг буруу үнэлсэн асуудалд орох эрсдэл үүсдэг,
- ЭМДҮЗ-ийн 2021 оны 01 дүгээр болон 2022 оны 06 дугаар тогтоолуудаар батлагдсан амбулаторийн үзлэг, оношилгоо шинжилгээ, шүдний сувгийн эмчилгээ, эрт илрүүлгийн багцын үзлэгийн өртөг нь бодит зардлаас багаар тогтоосноос эрүүл мэндийн байгууллагууд алдагдал хүлээж байна. Тухайлбал ЭМДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолоор лавлагаа шатны ЭМБ-д олгож байгаа санхүүжилтийг бодит өртөгтэй харьцуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 1		/сая төгрөг/		
№	Урьдчилан сэргийлэх үзлэгийн багц	ЭМДҮЗ-ийн 2022 оны 6 дугаар тогтоолоор	ЭМБ-д гарч байгаа бодит зардал	Зөрүү
1	18-30 насны иргэдийн багц	0.06	0.09	0.03
2	31-45 насны иргэдийн багц	0.13	0.21	0.08
3	46-60 насны иргэдийн багц	0.15	0.21	0.06
4	61-ээс дээш насны иргэдийн багц	0.14	0.21	0.07

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгийн тайлан

- Байгууллага жил бүр хүний нөөц, техник тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлж байгаа хэдий ч ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолд оношийн хамааралтай бүлгээр нэмэлт сонгон шалгаруулалт орох эрхийг нээлттэй болгоогүйгээс санхүүжилт нэмж авч чадахгүй эрсдэл үүссэн,
- ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолын дагуу сонгон шалгаруулалтад оролцоход зарим тусламж, үйлчилгээнд гэрээт хүний нөөцийг зөвшөөрдөггүйгээс оношийн хамааралтай бүлгийн эмчлэх эрхийг авч чаддаггүй,
- ӨЭМТ-ийн байр жижиг, өрөө тасалгааны хүрэлцээгүй учир хүний нөөцөө нэмэх, тусламж үйлчилгээ явуулахад хүндрэл үүсдэг гэх мэт.

Мөн аудитын явцад эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээтэй холбоотойгоор нийт 1000 гаруй даатгуулагчдаас цахим болон цаасан хэлбэрээр санал, асуулга авч нэгтгэн дүгнэхэд 60 хувь нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өрх, сумын ЭМТ-өөс ихэвчлэн авдаг, 43 хувь нь өрх, сумын ЭМТ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээг илүү чанар, хүртээмжтэй үзүүлдэг, 49 хувь нь эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар сайн, 55 хувь нь даатгуулагчдын эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн тусламж, үйлчилгээг үзүүлж чадаж байна гэж хариулсан байна.

Өөрөөр хэлбэл даатгуулагчдын 45-51 хувь нь эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний чанар хүртээмж, эмчилгээ, үйлчилгээнд сэтгэл ханамжгүй байна.



Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлж байна уу?

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлж, тусламж үйлчилгээнд хамруулах ажил хангалтгүй байна.

2.1. ЭМДС-ийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож байна уу?

2.1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого, зарлагын төлөвлөгөөг үндэслэлтэй батлуулж, орлогыг бүрэн төвлөрүүлж байна уу?

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9.1-д заасны дагуу ЭМДҮЗ нь ЭМДС-ийн төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулж, төсвийн нарийвчилсан хуваарийг баталж байгаа бөгөөд 19 дүгээр зүйлийн 19.1-д ЭМДС-ийн орлого 7 эх үүсвэрээс бүрдэнэ гэж заасан байдаг.

ЭМДҮЗ-ийн 2021 оны 01 дүгээр тогтоолыг үндэслэж, ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/11 дүгээр тушаалаар аймаг, нийслэлийн 2021 оны, ЭМДҮЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 08 дугаар тогтоолын үндэслэж, ЭМДЕГ-ын даргын 2022 оны А/14 дүгээр тушаалаар 2022 оны ЭМДС-ийн орлогын төлөвлөгөөг баталсан байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь “Энэ хуулийн 19.1.1, 19.1.2, 19.1.8-д заасан **шимтгэл, алдангийг цуглуулах, төвлөрүүлэх үйл ажиллагааг нийгмийн даатгалын байгууллага гүйцэтгэх бөгөөд үүнтэй холбогдсон харилцааг Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулна.**” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн НДХ нь ЭМДС-ийн орлогыг бүрдүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

ЭМДҮЗ-өөс баталсан Сэлэнгэ аймгийн ЭМДС-ийн орлогын төлөвлөгөө 2021 онд 9,715.8 сая төгрөг буюу 127.3 хувийн биелэлттэй, 2022 онд 11,728.6 сая төгрөг буюу 73.8 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна. ЭМДС-ийн орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр харуулбал:

ЭМДС-д 2021-2022 онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт 2

№	Үзүүлэлт	2021 он			2022 он		
		төлөвлөгөө	гүйцэтгэл	Биелэлт /хувь /	төлөвлөгөө	гүйцэтгэл	Биелэлт /хувь /
1	Даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл	453.7	493.8	108.8	922.8	662.0	71.7
2	Ажил олгогчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл	7,171.8	9,222.0	128.6	14,957.0	11,066.6	44.0
3	Бусад орлого	7.2		-			-
	Орлогын дүн	7,632.7	9,715.8	127.3	15,879.8	11,728.6	73.9

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021, 2022 оны санхүүгийн тайлан

ЭМДС-ийн 2021 оны орлогын төлөвлөгөөг 27.3 хувиар давуулан биелүүлсэн бол 2022 оны орлогын төлөвлөгөөг 26.1 хувиар тасалсан байна. Энэ нь 2021 онд 9,715.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн байхад 2022 оны орлогыг уг гүйцэтгэлээс 6,164.0 сая төгрөгөөр буюу 63.4 хувиар нэмэгдүүлэн хэт өндрөөр төлөвлөснөөс шалтгаалсан байна.

2.1.2. Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийг зохих журмын дагуу хянаж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаж байна уу?

Сэлэнгэ аймаг дахь ЭМДХ нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5³ болон ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/98 дугаар тушаалаар

³ даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон зардлын төлбөрт хяналт тавьж, энэ хуулийн 14.8.7-д заасан журамд тусгагдсан шалгуур хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлбөр олгох;

батлагдсан “Нэхэмжлэлийн хяналт хийх журам”, 2022 оны А/139 дүгээр тушаалаар батлагдсан “Нэхэмжлэхийг хянах журам”-ыг үндэслэн ЭМБ-уудын санхүүжилтийн нэхэмжлэлийг хянаж, гүйцэтгэлийг тайлагнасан байна.

ЭМДХ нь ЭМБ-уудад 2021 онд 23,258.4 сая төгрөгийн , 2022 онд 33,405.5 сая төгрөгийн санхүүжилтийг хянаж, олгосон байна.

ЭМДХ нь улирал бүр тайлан гаргаж, хагас, бүтэн жилийн эцэст олгохоор тооцсон санхүүжилтийг ЭМБ-уудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ЭМДЕГ-т үнэн зөв тайлагнасан байна.

2.1.3 Эрүүл мэндийн даатгалын байгууллага санхүүгийн болон хүний нөөцөө оновчтой удирдаж, батлагдсан төсвийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж байна уу?

Сэлэнгэ аймгийн НДХ-ийн ЭМД-ын тасаг нь ЭМДЕГ-ын 2020 оны А/136 дугаар тушаалаар ЭМДЕГ-ын Сэлэнгэ аймаг дахь ЭМДХ болж зохион байгуулагдан, 5 орон тоотойгоор */хэлтсийн дарга 1, чанар, төлбөрийн хэлтсийн мэргэжилтэн 4 /* үйл ажиллагаа явуулахаар батлагдсан байна.

Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 99 дүгээр тогтоолоор батлагдсан албан тушаалын тодорхойлолтод чанар, төлбөрийн хэлтсийн мэргэжилтний албан тушаал нь эмч, бизнесийн удирдахуй, эрх зүйч, эдийн засагч мэргэжилтэй байхаар тогтоосны дагуу сул ажлын байрны зарыг тухай бүр зарласан боловч шаардлага хангасан хүний нөөц бүрдээгүйгээс өнөөг хүртэл 2 орон тоо дутуу үйл ажиллагаа явуулж байна.

ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/119 дүгээр тушаалаар 2021 оны , 2022 оны А/08 дугаар тушаалаар аймгуудын 2022 оны ЭМДХ-ийн цалингийн зардлаас бусад үйл ажиллагааны зардлыг тус тус баталсан байна.

Сэлэнгэ аймгийн ЭМДХ-ийн цалингийн зардлаас бусад */бичиг хэрэг, шуудан холбоо, интернет, БҮТЭЗ, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний зардал г.м /* үйл ажиллагааны зардалд 2021 онд 11.8 сая төгрөг, 2022 онд 8.8 сая төгрөг батлагдсан байна.

Аймгийн ЭМДХ нь төрийн санд бие даасан харилцах дансгүй, төсөв захиран зарцуулах эрхгүй тул 2021 оны ажил, гүйлгээний нэхэмжлэхийг ЭМДЕГ-т хүргүүлж, гүйлгээ хийлгэсэн бол 2022 онд ЭМДЕГ-аас бичиг хэрэг, хангамжийн материалыг бэлтгэн нийлүүлж, шуудан холбоо, интернетийн нэхэмжлэхийг ЭМДЕГ-т хүргүүлж, ажил гүйлгээг гүйцэтгэсэн байна.

2.1.4. Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулах үйл ажиллагааг батлагдсан журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж байна уу?

ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд уг журмаар ЭМБ-ыг бус тусламж үйлчилгээг сонгон шалгаруулах өөрчлөлт орсон байна.

Өөрөөр хэлбэл өмнө нь ЭМБ-ын тухайн нэг тусламж, үйлчилгээг үзүүлэх чадамжийг үнэлэхгүйгээр байгууллагыг нь ерөнхий шалгуураар сонгож, сонгогдсон ЭМБ нь хүссэн тусламж, үйлчилгээгээ нэхэмжилдэг байсан байна.

Харин шинэчилсэн журмаар ЭМБ нь тухай тусламж, үйлчилгээг үзүүлэх чадамжтайгаа тусгай шаардлагын дагуу нотлон, зөвхөн тэнцсэн тусламж, үйлчилгээний төрөл дээр сонгогдох боломжтой болсон байна.

Сонгон шалгаруулалтыг ЭМДЕГ-аас зохион байгуулж байгаа бөгөөд 2022 онд Сэлэнгэ аймгийн лавлагаа шатны 8 ЭМБ 10 багцын давхардсан тоогоор 553 оношийн хамааралтай бүлгээр сонгон шалгаруулалтад орж тэнцсэн байна. Үүнийг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал:

*Оношийн хамааралтай бүлгээр сонгон шалгаруулалтад тэнцсэн
ЭМБ-уудын мэдээлэл*

Хүснэгт 3

№	ЭМТҮ-ийн багцын нэр	Аймгийн НЭ	Мандал сумын НЭ	Нямзул	ЭБУС	Асгатын дов	Энэрэлт үйлс	Тана	Анар
1	Амбулаторийн тусламж, үйлчилгээ	14	12	4	4	1	2	3	4
2	Диализын тусламж, үйлчилгээ	2	2						
3	Өдрийн эмчилгээ	5	1	1					
4	Өндөр өртөгтэй оношилгоо, шинжилгээ	4	1						
5	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	1							
6	Түргэн тусламж	4	4						
7	Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ	16	16		7	15			
8	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	1							
9	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	185	155	23	17	3	13	14	9
10	Яаралтай тусламж	5	5						
	Нийт дүн	237	196	28	28	19	15	17	13

Эх сурвалж: ЭМДЕГ-ын 2022 оны сонгон шалгаруулалтын тайлан

Тус журмын 4.1-д сонгон шалгаруулалтыг 3 жилд нэг удаа нэгдсэн журмаар зохион байгуулахаар заасан бөгөөд тусламж, үйлчилгээний нэр төрөлд нэмэлт, өөрчлөлт орсон эсхүл хүртээмж хангалтгүй байгаа тусламж үйлчилгээнд нэмэлт сонгон шалгаруулалтыг хугацаа харгалзахгүй зарлахаар заасан байна. Энэ нь ЭМБ-ууд журамд заасан тусгай шаардлага, шалгуурыг хангасан үедээ нэмэлт сонгон шалгаруулалтад орох, улмаар эмчилгээ үйлчилгээгээр өрсөлдөх боломжийг хязгаарлаж байна.Тухайлбал:

- Лавлагаа шатны ЭМБ-ууд нь 2022 оны 3-р сард анх оношийн хамааралтай бүлгийн сонгон шалгаруулалтад орох үедээ шинэчилсэн журмын талаар ойлголт хангалтгүй байснаас зарим оролцох боломжтой оношийн хамааралтай бүлгийн сонгон шалгаруулалтад материалаа өгөөгүйгээс эрх авч чадаагүй байна.
- Аймгийн нэгдсэн эмнэлэг нь 2023 онд эмэгтэйчүүдийн мэс заслын эмч болон хавдрын эмчтэй болж, 2023 оны 2-р сард нярайн тусламж үйлчилгээний 10, эмэгтэйчүүдийн дурангийн хагалгааны 4, хавдрын мэс заслын 12 оношийн хамааралтай бүлгээр сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ ЭМДЕГ-т хүргүүлсэн боловч өнөөг хүртэл шийдвэрлээгүй байна.
- Сүхбаатар сумын 2 өрхийн ЭМТ нь шинжилгээний тоног төхөөрөмжтэй болж лабораторийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтээ 2022 оны 12 дугаар сард ЭМДЕГ-т хүргүүлсэн боловч мөн л шийдвэрлээгүй байна.

ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам”-ын 5.5-д “Тусгай шаардлагад орон нутгийн хязгаарлагдмал нөөц, боломжийг харгалзан үзэж болно” гэж заасан атал аймгийн нэгдсэн эмнэлэг нь 2022 оны 11-р дүгээр сард 050421, 051931 гэсэн 2 оношийн хамааралтай бүлгээр сонгон шалгаруулалтад ороход зүрхний хэм алдалтаар мэргэшсэн эмчгүй, 042031, 0420211 гэсэн 2 оношийн хамааралтай бүлгээр ороход уушги судлалаар мэргэшсэн эмчгүй гэсэн үндэслэлээр тус тус татгалзсан байна.

Зүрх судас судлалаар төрөлжсөн мэргэшлийн 1 жилийн сургалтад хэм алдалтын талаар багц хичээл судалсан эмчийг бэлтгэсэн, улсын хэмжээнд уушги судлалаар мэргэшсэн эмч ховор байдаг, орон нутагт мэргэшсэн эмчийн дутагдалтай зэрэг байдлыг харгалзан үзэж тус оношийн хамааралтай бүлэгт тэнцүүлэхийг хүссэн албан тоотыг явуулсан боловч харгалзан үзээгүй байна.

2.1.5. Эрүүл мэндийн даатгалын байгууллага эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай даатгалын гэрээ байгуулж, гүйцэтгэлийг бодитой дүгнэж байна уу?

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т “Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь энэ хуулийн 16.1.4-т заасны дагуу сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага болон эмийн сантай даатгалын гэрээ /цаашид “гэрээ” гэх/-г байгуулах бөгөөд гэрээний хэрэгжилтийг хянаж, дүгнэнэ” гэж заасан бөгөөд ЭМДЕГ-ын даргын 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/142 дугаар тушаалаар “Даатгалын гэрээ дүгнэх журам”-ыг баталсан байна.

ЭМДЕГ нь 2021 онд аймгийн хэмжээнд лавлагаа шатны улсын 2, хувийн хэвшлийн 6 эмнэлэг, сум, тосгоны 21 ЭМТ, 3 өрхийн ЭМБ-тай, 2022 онд лавлагаа шатны улсын 2, хувийн хэвшлийн 6 эмнэлэг, сум, тосгоны 21 ЭМТ, 5 өрхийн ЭМБ-тай “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ”-г, 2021 онд 42, 2022 онд 39 эмийн сантай “Даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ”-г тус тус байгуулсан байна.

ЭМДЕГ-аас ЭМБ-тай байгуулсан 2021 оны гэрээний биелэлтийг ЭМДХ-ийн хянаж, дүгнэсэн саналыг үндэслэн дараах байдлаар дүгнэсэн байна. Үүнд:

- 2021 онд гэрээ байгуулсан нийт 24 өрх, сум тосгоны ЭМТ-ийн гэрээ дүгнэгдсэнээс 22 ЭМТ нь 85-100 оноотой дүгнэгдэж 2022 онд гэрээг үргэлжлүүлэн байгуулахаар, 2 сумын ЭМТ нь 75-80 оноотой дүгнэгдэж хугацаатай албан шаардлага хүргүүлэн, албан шаардлагын биелэлтийг үнэлсний дараа гэрээ байгуулах саналыг ЭМДЕГ-т хүргүүлсэн байна.
- 2021 онд гэрээ байгуулсан 42 эмийн сангийн гэрээг дүгнэхээс 38 эмийн сангийн гэрээг 81-96 оноотой дүгнэж, 2022 онд гэрээг үргэлжлүүлэн байгуулах, гэрээ дүгнүүлээгүй 4 эмийн сангийн гэрээг цаашид сунгахгүй байх зэрэг саналуудыг ЭМДЕГ-т хүргүүлсэн бол 2022 онд 39 эмийн сангийн гэрээг дүгнэхээс 38 эмийн сангийн гэрээг 75-90 оноотой дүгнэж 2023 онд үргэлжлүүлэн байгуулахаар, дүгнүүлээгүй Сэлэнгэ талст эмийн сангийн гэрээг цаашид сунгахгүй байх зэрэг саналуудыг ЭМДЕГ-т хүргүүлсэн байна.
- 2021 онд гэрээ бүхий лавлагаа шатны улсын 2, хувийн хэвшлийн 6 эмнэлгүүдийг “Хангалттай” үнэлэн “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах 2022 оны гэрээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

ЭМДЕГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/61 дүгээр тушаалаар баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээний биелэлтийг үнэлэх, урамшуулал олгох журам”-д гэрээг дараа оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор дүгнэхээр заасан байдаг.

Гэтэл шинэчлэн батлагдсан журамд тусгасан эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийг дүгнэх гэрээний шалгуур үзүүлэлтүүдийн хүрэх түвшин болон хүрсэн түвшинг тооцож байгаа аргачлал нь тодорхой бус, мэдээллийг байршуулж буй программд хөгжүүлэлт хийгдээгүй, эмч мэргэжилтнүүдэд хийгдсэн сургалт хангалгүй зэргээс шалтгаалан 2022 оны гэрээг дүгнээгүй, 2023 оны гэрээг өнөөг хүртэл байгуулаагүй байна.

Аудитаар лавлагаа шатны улсын 2, хувийн 2 эмнэлгийн, 5 ӨЭМТ-ийн, сум тосгоны 18 ЭМТ-ийн нийт 27 удирдах ажилтнуудтай хийсэн ярилцлагын явцад “Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь ЭМБ-тай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг бодитой үнэлж, дүгнэж байна уу?” гэсэн асуултад бодитой үнэлдэг гэж 10, бодитой үнэлж чаддаггүй гэж 14 удирдах ажилтан хариулсан бөгөөд 3 нь мэдэхгүй гэж хариулсан байна.

Өөрөөр хэлбэл эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг дүгнэх шалгуур үзүүлэлт нь тодорхой бус дүгнэх аргачлал нь орон нутгийн онцлогт тохирохгүй байгаагаас шалтгаалан гэрээг бодитой үнэлж, дүгнэж чадахгүй байна.

2.1.6. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад олгосон санхүүжилт үр нөлөөтэй байна уу?

ЭМДС-аас олгож буй нэг худалдан авагчийн тогтолцоонд шилжсэн санхүүжилт нь иргэн даатгуулагчийг бүх төрлийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үзлэг,

оношилгоонд хамрагдахад ЭМД-ын хөнгөлөлт эдлүүлэх, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй улсын болон хувийн хэвшлийн ЭМБ-ууд 2021 онд 389,846 иргэн даатгуулагчид үйлчилгээ үзүүлж 23,258.4 сая төгрөгийн, 2022 онд 499,403 иргэн даатгуулагчид үйлчилгээ үзүүлж 33,405.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

*Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ"-ний гүйцэтгэлээр
2021-2022 онд олгосон санхүүжилт*

Хүснэгт- 4

Д/д	Байгууллагын нэр	2021 оны санхүүжилтийн тооцоо			2022 оны санхүүжилтийн тооцоо			/сая төгрөгөөр/ Өсөлт бууралтын зөрүү		
		Тусламж үйлчилгээ үзүүлсэн иргэний тоо	Олгосон санхүүжилт	Нэг хүнд ноогдох мөнгөн дүн	Тусламж үйлчилгээ үзүүлсэн иргэний тоо	Олгосон санхүүжилт	Нэг хүнд ноогдох мөнгөн дүн	Иргэний тоо	Мөнгөн дүн	Нэг хүнд ноогдох дүн
1	Улсын лавлагаа шатны ЭМБ	130,889	7,808.21	0.06	235,085	14,445.57	0.06	104,196	6,637.36	0.00
2	Сум, тосгоны ЭМТ	15,311	392.30	0.03	109,424	11,378.03	0.10	94,113	10,985.73	0.08
3	Өрхийн ЭМТ	-	-	-	49,800	3,074.54	0.06	49,800	3,074.54	0.06
4	Хувийн хэвшлийн ЭМБ	3,420	1,620.21	0.47	3,843	1,856.24	0.48	423	236.03	0.01
5	Ковид-19 вакцин	122,328	611.64	0.01	16,074	80.37	0.01	(106,254)	(531.27)	-
6	Ковид-19 сорьц авах	35,454	1,058.91	0.03	14,656	419.24	0.03	(20,798)	(639.67)	(0.00)
7	Ковид-хэвтэн эмчлүүлсэн	16,002	9,911.10	0.62				(16,002)	(9,911.10)	(0.62)
8	Эм ханган нийлүүлэгч байгууллага	66,442	1,855.99	0.03	70,521	2,151.52	0.03	4,079	295.53	0.00
	Нийт дүн	389,846	23,258.37	0.06	499,403	33,405.52	0.07	109,557	10,147.15	0.01

Эх сурвалж: Сэлэнгэ аймаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн 2021, 2022 оны санхүүгийн тайлан

2021 онд өрхийн эрүүл мэндийн төвүүд эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулаагүйгээс төсвөөс 1 иргэнээр тооцон санхүүжилт авч байсан бол сум, тосгоны ЭМТ -нь зөвхөн байгуулсан гэрээний дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг авч, 1 иргэнээр тооцсон санхүүжилтийг төсвөөс авч үйл ажиллагаагаа явуулсан байна.

Гүйцэтгэлийн үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан иргэн даатгуулагчийн тоо өмнөх оноос 109,557 хүнээр, ЭМБ-уудад олгосон санхүүжилт 10,147.1 сая төгрөгөөр, нэг хүнд ноогдох эмчилгээ үйлчилгээний зардал дунджаар 0.01 сая / 10.0 мянга / төгрөгөөр тус тус өссөн байна.

ЭМДС-аас 2021 онд цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан коронавируст халдвар Ковид-19-өөс урьдчилан сэргийлэх вакцин, сорьц шинжилгээ болон гэрийн эмчилгээ, хэвтэн эмчилгээ зэрэгт нийт санхүүжилтийн 49.8 хувь буюу **11,581.7** сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. /2021 оны санхүүжилтийн дэлгэрэнгүйг хавсралт 1-д харуулав/

ЭМДС-аас үзүүлэх эмийн үнийн хөнгөлөлтийг зөвхөн өрх, сум, тосгоны эмчийн бичсэн жороор олгодог байсан бол бүх шатны ЭМБ-ын цахим эмийн жор бичих эрх бүхий эмчийн жороор олгодог болсноор хөнгөлөлттэй эмээр үйлчлүүлсэн иргэний

тоо өмнөх оноос 2,972 хүнээр, санхүүжилт 295.5 сая төгрөгөөр өссөн байна. /дэлгэрэнгүйг хавсралт 2-т харуулав/

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т гэрээний дагуу зардлын урьдчилгаа төлбөр олгож болно гэж заасны дагуу аймгийн ЭМДХ нь улсын болон хувийн лавлагаа шатны эмнэлэг, сум тосгоны ЭМТ-ийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлд үндэслэн, гэрээний дагуу 80 хувийн урьдчилгаа санхүүжилтийг олгосон байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, ЭМДҮЗ-ийн 2021 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ”- ний 2 дугаар зүйлийн 5.3-т “... төр хариуцах тусламж үйлчилгээнд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн үлдэгдэл болох 20 хувийг гэрээ дүгнэснээс хойш ажлын 10 хоногийн дотор олгоно.” гэж тус тус заасан байдаг.

Гэвч ЭМДЕГ-ын даргатай байгуулсан 2022 оны гэрээг сар бүр дүгнээгүйгээс өрх, сум тосгоны 26 анхан шатны ЭМБ-ын 20 хувийн үлдэгдэл санхүүжилтийг сар бүр тогтмол олголгүйгээр ЭМДҮЗ-ийн 2022 оны 4 дүгээр тогтоолоор 4-6 сарын, 10 дугаар тогтоолоор 7-10 сарын санхүүжилт нийт **783.0 сая** төгрөг, 2023 оны 01 дүгээр тогтоолоор 2022 оны 11, 12 дугаар сарын **276.5 сая** төгрөгийг 2023 оны 2 дугаар сард тус тус бөөнөөр нь олгосон байна.

ЭМДС-аас санхүүжилтийг тухай бүр олгохгүй байгаа нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын хүн амд үзүүлэх анхан шатны цогц тусламж, үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй, тасралтгүй хүргэхэд санхүүгийн эх үүсвэр дутагдах эрсдэлийг үүсгэж байна.

2022 онд Өрхийн эрүүл мэндийн төв болон аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын даргатай байгуулсан “Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээ”-ний 4.1.1-д “ Аймгийн Засаг дарга нь ЭМТ-ийг эмнэлгийн зориулалтын байраар хангаж, засвар үйлчилгээ, дулаан, цахилгаан, цэвэр усаар хангагдах нөхцөлийг бүрдүүлэн, тогтмол зардлыг хариуцан, төвийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах,” гэж заасан боловч 2022 оны аймгийн төсөвт өрхийн эрүүл мэндийн төвүүдийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг тусгаж, батлаагүйгээс өрхийн ЭМТ-үүд нь “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах гэрээ”-ний гүйцэтгэлийн санхүүжилтийн орлогоос 2021 онд 14.3 сая төгрөг, 2022 онд 38.5 сая төгрөг, нийт **52.8 сая** төгрөгийг тогтмол зардалд зарцуулсан байна.

Энэ нь иргэдэд үзүүлж буй анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилт нь зохих хууль журмын дагуу зарцуулагдаагүйгээс эмчилгээ үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг үүсгэж байна.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн ЭМБ-ууд нь 2022 онд нийт 36,793.9 сая төгрөгийн /гүйцэтгэлийн санхүүжилт болон бусад/ орлого

төвлөрүүлж, 35,347.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Дэлгэрэнгүйг хүснэгтээр харуулбал:

Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын / төрийн / 2022 оны орлого, зарлагын судалгаа

Хүснэгт- 5

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Оны эхний дансны үлдэгдэл	Нийт орлого, эх үүсвэр	Орлогын төрөл					Нийт зарцуулалт	Зардлын эдийн засгийн ангилал				
			Нэг иргэнээр тооцсон санхүүжилт	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний орлого	Урьдчилан сэргийлэх /лаборатори/	Орон нутгаас тогтмол зардлын санхүүжилт	Бусад орлого		Цалин НДШ зардал	Эмчилгээ үйлчилгээний бусад зардал	Тогтмол зардал	Эд хогшил, болон хөрөнгийн зардлын дүн	Нэг удаагийн тэтгэмж, урамшууллын дүн
А	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Лавлагаа шатны эмнэлэг	80.4	17,206.2	-	12,943.7	143.2		4,119.3	17,274.5	10,233.7	5,218.1	1,593.1	208.4	21.2
Сум тосгоны ЭМТ	-	16,712.8	6,745.5	4,632.5	0.2	1,023.3	4,311.3	15,268.6	8,425.0	4,540.3	926.8	1,336.4	40.0
ӨЭМТ	0.1	2,875.0	1,923.5	25.8	-	-	925.7	2,803.9	1,936.2	615.7	37.5	170.7	43.8
НИЙТ ДҮН	80.5	36,793.9	8,669.0	17,602.0	143.3	1,023.3	9,356.3	35,347.0	20,594.9	10,374.1	2,557.4	1,715.6	105.0

Эх сурвалж: Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлан

Лавлагаа шатны эмнэлгүүдийн нийт зардалд цалин, НДШ, урамшууллын зардал 59.2 хувийг, эмчилгээ үйлчилгээний зардал 30.2 хувийг, тогтмол зардал 9.2 хувийг, эд хогшил болон хөрөнгө худалдаж авах зардал 1.2 хувийг эзэлж байгаа бол сум тосгоны ЭМТ-ийн нийт зардалд цалин, НДШ, урамшууллын зардал 55.2 хувийг, эмчилгээ үйлчилгээний зардал 29.7 хувийг, тогтмол зардал 6.1 хувийг, эд хогшил болон хөрөнгө худалдаж авах зардал 8.8 хувийг эзэлж байна.

Гэтэл ӨЭМТ-ийн нийт зардалд цалин, НДШ, урамшууллын зардал 69.1 хувийг, эмчилгээ үйлчилгээний зардал 22.0 хувийг, тогтмол зардал 1.3 хувийг, эд хогшил болон хөрөнгө худалдаж авах зардал 6.1 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд цалин, НДШ, урамшууллын зардал нь төрийн хэвшлийн бусад эрүүл мэндийн байгууллагуудаас даруй 9.9-13.9 хувиар их байна. /дэлгэрэнгүйг хавсралт 3-т харуулав/

Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь ЭМД-ын сангаас болон төсвөөс /тогтмол зардал/ бүрэн санхүүжигдэж байгаа боловч нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг гэх үндэслэлээр хөрөнгө, санхүүжилтийн зарцуулалт, ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтоолт болон төрөөс хяналт шалгалт хийх хууль эрх зүйн актын зохицуулалтгүйгээс ЭМДС-ийн санхүүжилтийн дийлэнх хувийг эмчилгээ, тусламж үйлчилгээнд бус ажилтнуудын цалин хангамжийг нэмэгдүүлэх болон бусад чиглэлээр зарцуулах сөрөг хандлагыг бий болгож байна.

2021 оны 11,12 дугаар сарын Ковид 19 өвчний санхүүжилтийг 2022 онд олгосноос ЭМТ-ийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдэж, 12 сумын ЭМТ-ийн төсвийн шууд захирагчийн шийдвэрээр ажилтнуудын цалинг 10-50 хувиар, сумын Засаг даргын шийдвэрээр Сант, Орхон сумын ЭМТ-ийн даргын цалинг 20-44.2 хувиар тус тус нэмэгдүүлэн цалингийн зардлыг нийт 351.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн нь Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 2 дахь заалтыг зөрчсөн байна.

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн байгууллагуудын эмчилгээ үйлчилгээг ЭМДС-аас санхүүжүүлж, 1 иргэнд ногдох санхүүжилт нэмэгдэн, төсвийн ачааллыг тодорхой хэмжээгээр бууруулсан байна.

Эрүүл мэндийн даатгал, үрд дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө

Аймгийн ЭМБ-уудын 2021, 2022 оны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд

Хүснэгт-6

д/д	Шалгуур үзүүлэлт	2020 оны суурь үзүүлэлт	2021 он			2022 он		
			Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	зөрүү	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	зөрүү
1	Эхийн эндэгдлийн түвшин /100,000 амьд төрөлт тутамд/	0	0	123.2	123.2	123.2	0	(123.2)
2	Нялхсын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/	8.5	8	11.2	3.2	10.5	9.8	(0.7)
3	Нярайн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлт тутамд/	5.4	4.9	6.5	1.6	6.2	5.7	(0.5)
4	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1,000 амьд төрөлт тутамд/	12.7	12.0	15.1	3.1	14.8	6	(8.8)
	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин /10,000 хүн амд/	10.5	10.0	5.9	(4.1)	7.7	7.6	(0.1)
6	Вируст гепатитын өвчлөлийн түвшин /10,000 хүн амд/	0.2	0.1	0	(0.1)	0	0	0
7	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин /10,00 хүн амд/	17.4	17.2	18.3	1.1	21.7	18.4	(3.3)
8	Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин /10,000 хүн амд/	14.4	13.9	10.1	(3.8)	12.1	24.2	12.1
9	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин /10,000 хүн амд/	0.9	0.7	0.7	0	1.9	1.2	(0.7)
10	Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин /10,000 хүн амд/	1.2	0.9	0.6	(0.3)	1.1	1.2	0.1
11	0-5 хүртэлх насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин /10,000 хүүхдэд T20-T32/	38.7	37.7	17.7	(20)	23.9	96.3	72.4
12	Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин /10,000 хүүхдэд, V00-V99/	1.2	1.0	4.3	3.3	0.9	5.3	4.4
13	Хүн амын дундаж наслалтыг уртасгах. /2021-2025 онд 71-74т хүргэх/	71.96	71.6	71.78	0.18	72.2	71.82	(0.38)

Эх сурвалж: 2021, 2022 онд ЭМС, аймгийн Засаг даргын нарын хооронд байгуулсан гэрээний биелэлтийн тайлан.

Дээрхээс харахад 2021 онд анхан шатны болон лавлагаа шатны эмнэлгүүд нь ковид-19 цар тахлыг эмчлэх бэлэн байдлын зэрэгт шилжин коронавирусийн эмчилгээний ор дэлгэснээс эрт илрүүлгийн үзлэгүүд багасаж зорилтод түвшиндээ хүрээгүй, зонхилон тохиолдох өвчний эмчилгээ, үйлчилгээ буурсан байна.

2022 онд санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин 0.1 ээр, 0-5 хүртэлх насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин 72.4-өөр, хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин 4.4- өөр зэрэг ердийн өвчлөлөөс бус ахуйн осол, гэмтлээс шалтгаалсан өвчлөл, нас баралт тус тус хүрэх түвшнээс нэмэгдсэн байна.

Энэ нь Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь “Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх” гэсэн заалт болон Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/52 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан сум тосгоны ЭМТ-ийн үзүүлэх “Нийгмийн эрүүл мэндийн

тусламж үйлчилгээ"-ний буюу өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаагаас шалтгаалсан байна.

2.2. Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн салбарт тодорхой ахиц дэвшил гарч байна уу

2.2.1. Эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлж, тусламж үйлчилгээнд хамруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнтэй ажиллаж байна уу?

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амыг тодорхойлж, тусламж үйлчилгээнд хамруулах үйл ажиллагаа нь тэдгээрийг эрүүл мэндийн даатгалд зайлшгүй хамруулах замаар шийдвэрлэгдэх учиртай юм.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-д “Монгол Улсын иргэн эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээ хуваалцах зорилгоор эрүүл мэндийн албан журмын даатгалд заавал даатгуулна”, 19 дүгээр зүйлийн 19.3-т “Энэ хуулийн 19.1.1, 19.1.2, 19.1.8-д заасан шимтгэл, алдангийг цуглуулах, төвлөрүүлэх үйл ажиллагааг нийгмийн даатгалын байгууллага гүйцэтгэх бөгөөд үүнтэй холбогдсон харилцааг Нийгмийн даатгалын тухай хуулиар зохицуулна.” гэж заасан байна.

Албан ёсны статистикийн тоон үзүүлэлт болон аймгийн НДХ-ийн тайлан мэдээнээс харахад 2021 онд аймгийн нийт хүн амын 12.4 хувь болох 13,536 иргэн, 2022 онд 10.9 хувь болох 11,718 иргэн ЭМД-д хамрагдаагүй байна.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын судалгаа

Хүснэгт 7:

№	Үзүүлэлт	2021 он	2022 он
1	Хамрагдвал зохих даатгуулагчийн тоо	108,887	107,428
2	Хамрагдсан даатгуулагчийн тоо / хүүхэд, өндөр настан орсон /	95,351	95,710
	Хамрагдаагүй даатгуулагчийн тоо	13,536	11,718

Эх сурвалж: Аймгийн статистикийн 2021, 2022 оны мэдээ, нийгмийн даатгалын тайлан

ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/10 дугаар “Хамралтын төлөвлөгөө батлах тухай” тушаалаар Сэлэнгэ аймагт шинээр ЭМД-д хамруулах иргэний / малчин, оюутан, хувиараа хөдөлмөр эрхлэгч / 2021 оны төлөвлөгөөг нийт 15,600 иргэн, 2022 оны А/13 дугаар тушаалаар тус оны төлөвлөгөөг нийт 14,750 иргэнээр тус тус баталснаас 2021 онд 44.1 хувийн, 2022 онд 67.8 хувийн гүйцэтгэлтэй тайлагнагдаж, хамруулбал зохих иргэдийн төлөвлөгөөг 2021 онд 55.9 хувиар, 2022 онд 32.2 хувиар тус тус тасалсан байна.

Эрүүл мэндийн даатгалд шинээр хамруулах ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүснэгт: 8

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2021 он				2022 он			
		Төлөвлөгөө	Хамрагдалт	Хамралтын хувь	Шимтгэлийн орлого	Төлөвлөгөө	Хамрагдалт	Хамралтын хувь	Шимтгэлийн орлого
1	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	9,500	5,019	52.8	357.2	8,550	7,454	87.2	490.5
2	Малчин	4,800	1,236	25.8	99.8	4,100	1,570	38.3	111.8
3	Оюутан, суралцагч	1,300	624	48.0	36.8	2,100	976	46.5	59.7
	Нийт дүн	15,600	6,879	44.1	493.8	14,750	10,000	67.8	662.1

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2021, 2022 оны тайлан

Хамрагдалтын төлөвлөгөөний хэрэгжилтээс харахад малчин иргэдийн хамрагдалт 2021 онд 25.8 хувь, 2022 онд 38.3 хувьтай тайлагнагдсан нь хамгийн бага байна.

Энэ нь шинээр хамруулах иргэдийн төлөвлөгөөг батлахдаа бодит тооцоо судалгаанд үндэслээгүй, өөрөөр хэлбэл шинээр хамруулах малчин иргэдийн тоог малчны үнэмлэх авсан иргэдийн тоогоор төлөвлөсөн, тахир дутуугийн болон өндөр настны тэтгэвэр авагч буюу даатгалыг төрөөс хариуцдаг иргэдийг давхардуулан тооцсон, оюутан суралцагчдын тоонд аймгийн 3 МСҮТ-д суралцагч насанд хүрээгүй хүүхдүүдийг оролцуулан тооцсон зэргээс болон ЭМД-ийн ач холбогдлыг иргэд даатгуулагчдад сурталчлах ажил хангалтгүй зэргээс шалтгаалсан байна.

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн ам, тэдгээрийг ЭМД-д хэрхэн хамруулах талаар тодорхойлсон бодит тооцоо судалгаа хийгдээгүй, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна.

2.2.2. Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд даатгуулагч, эмнэлэг, эмийн сан, даатгалын байгууллага болон бусад төрийн байгууллагыг холбосон найдвартай цахим мэдээллийн системийг хөгжүүлж, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах, чанартай тусламж, үйлчилгээг үзүүлэх нөхцөл бүрдсэн үү?

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8-д “Эрүүл мэндийн даатгалын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэх”, 23 дугаар зүйлийн 23.2.3-т “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын болон төлбөрийн хяналтыг энэ хуулийн 14.8.7-д заасан журмын дагуу цахим болон бусад хэлбэрээр хэрэгжүүлэх” гэж заасан байна.

Аймгийн ЭМБ-ууд нь төрийн мэдээлэл солилцооны “Хур” системээр дамжуулан бусад байгууллагуудтай мэдээлэл солилцдог цахим мэдээллийн

системүүдийг үйл ажиллагаандаа ашиглаж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Үүнд:

- Лавлагаа шатлалын ЭМБ-ууд E-Health, h-info, H info v-3, E-clinic,
- Өрх, сум, тосгодын эрүүл мэндийн төвүүд E-Health, E-hospital, h-info, H info v-3
- Сумдын эмийн сангууд хөнгөлөлттэй эмийн Orion, Сэцэн программ,
- Хувийн эмнэлэг нь Wings, аксис гэх мэт.

ЭМБ-ууд нь цахим системд шилжсэнээр иргэд даатгуулагчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд дараах давуу талууд бий болсон байна. Үүнд:

- ЭМБ-аас оношилгоо, шинжилгээ, амбулаторийн тусламж, үйлчилгээний мэдээллийг цахим хэлбэрээр авдаг болсон, өвчтөний түүхийн цахим сан үүссэн,
- Үзлэгийн цагийг онлайнаар захиалснаар иргэдийн цагийг хэмнэсэн, оношилгоо болон шинжилгээний дугаар болон хариу авах зэрэг үйл явцыг хялбарчилсан,
- Үзлэгийн кабинетууд болон тасгууд, лаборатори хоорондоо цахимаар холбогдон оношилгоо, үзлэгийн дугаар авах, шинжилгээнд илгээх, хариу авах, яаралтай тусламжийг эрэмбэлэн цаг алдалгүй оношилгоо шинжилгээнд илгээх, хариуг хүргэх ажлууд шуурхай болсон,
- Цахим эмнэлгийн хуудас буюу ХЧТА-ын эмнэлгийн хуудсыг цахимаар илгээж хянадаг болсон нь цаас, цаг хугацааг хөнгөвчилсөн,
- Эмийн хөнгөлөлт үзүүлэх цахим жорыг нэвтрүүлснээр эмийн зохисгүй хэрэглээг хязгаарлан, даатгуулагч эмчээр эмээ бичүүлэн, хүссэн эмийн сангаас оочир дараалал хүлээлгүйгээр хөнгөлөлттэй эмээ авдаг болсон,
- E-mongolia.mn платформ болон E-баримт цахим системд ЭМД-ын шимтгэл төлөлтийн байдлаа харах болон шимтгэлээ төлөх 2 төрлийн үйлчилгээг нэвтрүүлснээр мэдээллийн баазад шимтгэл төлөлт 10-20 минутын дотор баталгаажих болсон гэх мэт.

Аудитын явцад холбогдох ажилтнуудтай хийсэн асуулга, ярилцлага, хийгдсэн судалгаанаас харахад дээрх программ хангамжийг ашиглахад дараах хүндрэл бэрхшээл тулгарч байна. Үүнд:

1. E-Health программын хувьд:

- Гацалт их байдгаас иргэдэд хүлээлт үүсдэг,
- Өөр өөр оноштой байхад нэг л үндсэн оношийн мэдээлэл орох тохиргоотой,
- Цахимаар 13а маягт илгээсэн тохиолдолд илгээсэн хүний тоо мэдээлэл харагддаггүй,
- Эмийн программ 17 цагт хаагддаг тул дуудлага буюу яаралтай тусламж үзүүлсэн хүмүүст 17 цагаас хойш эм бичих боломжгүй,
- 2 оношоор хөнгөлөлттэй эм бичихэд 10-15 мин хүлээж, 2 дахь оношийн эмээ бичдэг,
- ЭМДС-ийн нэхэмжлэлийн хасагдлын шалтгааныг харах боломж байдаггүй.

2. E-hospital программын хувьд:

- Гацалт ихтэй, ажиллагаа их, олон үйлдэлтэй
- ЭМДС-ийн нэхэмжлэлийн хяналтын хасагдлын шалтгааныг харах боломжгүй,
- Бичигдсэн буруу мэдээллийг дахин засах боломжгүй,
- Тусламж, үйлчилгээний шивэлт хийхийн тулд маш олон цонхонд орж, гарах шаардлагатай болдог,

- Олон оношийг зэрэг тавьж тусламж үйлчилгээний шивэлт хийх боломж бүрдээгүй,
- Анхан шатны маягтууд ЭМС-ын А/611 дүгээр тушаалаас зөрдөг,
- Мэдээллийг шүүлт хийж харах, дүгнэх боломжгүй.
- Жирэмсний хяналт хэсгээс хяналтад орсон хугацаа, огноо, шилжин явсан огноо зэргийг шүүлт хийж харах боломжгүй.

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэдэд хүргэх үйл ажиллагааг цахим системд шилжүүлснээр төвлөрсөн мэдээлэл солилцооны платформ бий болгож, иргэд, даатгуулагчдын цаг хугацааг хэмнэх, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлэх нэг нөхцөл болсон байна.

2.2.3. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар даатгуулагчийг шаардлагатай мэдээллээр хангах, ирүүлсэн өргөдөл, гомдлыг хууль тогтоомж, журамд заасны дагуу шийдвэрлэж байна уу?

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 16 дугаар зүйлийн 16.1.11-д заасны дагуу Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, холбогдох дүрэм, журмын талаарх мэдээллийг сурталчлан таниулах зорилгоор аймгийн ЭМДХ нь олон нийтийн цахим сүлжээ, байгууллагын ил тод байдлын мэдээллийн самбараар дамжуулан иргэдэд мэдээ, мэдээллийг түгээж байна. Үүнд:

- 13а маягтай холбоотой мэдээллийг ЭМГ болон аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран Сэлэнгэ-цахим телевизээр түгээсэн,
- Хэлтсийн фэйсбүүк хуудсанд эрүүл мэндийн даатгалтай холбоотой 276 мэдээллийг байршуулсан бөгөөд 2021 онд 590 хандалттай байсан бол 2022 онд 790 болж өссөн байна.

ЭМДЕГ нь даатгуулагч иргэд ЭМБ-аар үйлчлүүлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авсан өөрийн мэдээлэл буюу түүхийг харах, хянах болон авсан тусламж үйлчилгээндээ сэтгэл ханамжийн үнэлгээ өгөх зэрэг өгөгдөлтэй Е-даатгал аппликейшн болон ЭМБ-аар үйлчлүүлж эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан иргэдийн гар утсанд мессеж илгээх, асуумж авах зэрэг ухаалаг утасны үйлчилгээнүүдийг нэвтрүүлснээр иргэний оролцоотой даатгалын хяналтын системийг бий болгосон байна.

Гэвч Е-даатгал аппликейшнийг аймгийн хэмжээнд 2021 онд 1148 даатгуулагч буюу 20-65 насны хүн амын зөвхөн 1.9 хувь нь, 2022 онд 1333 даатгуулагч буюу 2.2 хувь нь л ашиглаж байгаа нь уг аппликейшний талаарх мэдээллийг иргэд, даатгуулагчдад хүргэх ажиллагаа хангалтгүй болохыг харуулж байна.

Аудитын явцад санал асуулгад хамрагдсан 1000 гаруй иргэний 25 хувь нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээлэл хангалтгүй байдгаас эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэхэд хүндрэл, бэрхшээл үүсэж байна гэсэн бол ЭМДХ-ийн үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг 7 хувь нь маш сайн, 39 хувь нь сайн, 44 хувь нь дунд, 10 хувь нь муу гэж дүгнэсэн байна.



ЭМДХ нь даатгуулагчдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийг ихэвчлэн цахим сүлжээгээр хүргэж байгаа хэдий ч нийт хүн амыг хамраагүй, цахим сүлжээ ашигладаггүй даатгуулагчдад хүрч чадахгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх “Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ” 16.1.12: “Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх”, 23 дугаар зүйлийн 23.2.2 дахь “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн талаар даатгуулагчийн гаргасан өргөдөл, гомдол, саналыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж, даатгуулагчийн эрхийг хамгаалах” гэсэн заалтуудын дагуу иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэсэн байна.

Аймгийн ЭМДХ-т хандан иргэдээс 2021, 2022 онд нийт 9 өргөдөл, гомдол ирүүлсний 77.8 хувь нь бичгээр, 11.1 хувь нь утсаар хандан ирүүлсэн байна.

Хүснэгт 9: Эрүүл мэндийн даатгалын байгууллагуудад ирүүлсэн өргөдөл, гомдол, шийдвэрлэлт

№	Өргөдөл, гомдлын төрөл	2021 он	2022 он	Үүнээс шийдвэрлэлт:		
				Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн
1	Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээтэй холбоотой	1	5	4	2	
2	Эмч, ажилчдын мэргэжлийн чадвар харилцаа хандлага ёс зүйтэй холбоотой		1		1	
3	Бусад	1	1	1	1	
	Нийт дүн	2	7	5	4	

Эх сурвалж: 2021, 2022 оны өргөдөл, гомдлын судалгаа

2021, 2022 онд ирүүлсэн нийт өргөдөл, гомдлын 66.7 хувийг эрүүл мэндийн даатгалын үйлчилгээтэй холбоотой, 11.1 хувийг эмч, ажилчдын мэргэжлийн чадвар, харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой асуудлууд эзэлж байгаа бол 22.2 хувийг эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тодорхойлолт авах гэх мэт бусад асуудлууд эзэлж байна.

2.3 Эрүүл мэндийн даатгалын салбарын хяналт, шалгалт, дотоод аудитын үйл ажиллагаа үр нөлөөтэй байна уу?

2.3.1 Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээний хэрэгжилтэд хууль тогтоомж, журамд заасны дагуу хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, үр дүнг тооцож байна уу?

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Дээрх журамд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд дараах байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээ хийхээр зохицуулсан байна. Үүнд:

1. Үндэсний хэмжээнд хэрэгжих бодлогын баримт бичиг:

- Тус тогтоолоор орон нутгийн түвшинд нутгийн захиргааны байгууллага эрхлэх асуудлын хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод 5 жил тутамд, явцад 2 жил тутамд, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх,
- Хөгжлийн зорилтод хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад 5 жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх,
- Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд 2 жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх,
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад жил тутамд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх,

2. Орон нутгийн хэмжээнд хэрэгжих бодлогын баримт бичиг:

- Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд жил бүр,
- Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад жил бүр,
- Аймгийн хөгжлийн төлөвлөгөөний биелэлтэд жил бүр,
- Урт болон дунд хугацаанд хэрэгжих бодлогын баримт бичгийн хугацаа дуусмагц эцсийн үнэлгээ болон бодлогын баримт бичгийн үр нөлөөний үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж тайланг ЗГХЭГ-т хүргүүлэхээр тус тус заасан байна.

Гэвч аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын зүгээс үндэсний хэмжээнд хэрэгжих эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, түүний үр дүнтэй холбогдох урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт явцын хяналт- шинжилгээ, үнэлгээг огт хийгээгүй байна.

Харин аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан эрүүл мэндийн бодлогын зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 6.2-т заасан хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй, аймгийн Засаг даргын 2017 оны А/458 дугаар захирамжаар батлагдсан “Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, хугацаатай

тайлан, мэдээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам"-ыг үндэслэн зорилтот түвшинд хүрсэн эсэхийг үр дүнг харьцуулах байдлаар хяналт, шинжилгээ хийсэн байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан эрүүл мэндтэй холбоотой 14 зорилтоос 7 зорилт нь 100 хувь, 2 зорилт нь 90 хувь, 1 зорилт 70 хувь, 3 зорилт нь 50 хувь, 1 зорилт нь 30 хувь буюу дунджаар **80.7** хувьтай үнэлсэн байна.
- Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 15 арга хэмжээнээс 6 арга хэмжээ 100 хувь, 3 арга хэмжээ 90 хувь, 4 арга хэмжээ 70 хувь, 2 арга хэмжээ 50 хувь буюу дунджаар **74.0** хувийн хэрэгжилтэй
- Аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан 1 зорилт 11 арга хэмжээнээс 10 арга хэмжээ 10 хувь, 1 арга хэмжээ огт хэрэгжээгүй гэж үнэлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь Эрүүл мэндийн газар болон ЭМДХ-ийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ бодлого, үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг хэрхэн тодорхойлсон нь тодорхойгүй, хэрэгжилт дутуу болон хэрэгжээгүй арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тодорхойлж, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж боловсруулж хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулаагүй байна.

Өөрөөр хэлбэл эрүүл мэндийн салбарын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтэд тогтоосон хугацаанд хяналт-шинжилгээ үнэлгээг журамд заасны дагуу хийгээгүй бөгөөд аймгийн ЭМГ, ЭМДХ-ийн үйл ажиллагаанд өөрсдийнх нь бичсэн тайланд үндэслэж үнэлгээ хийсэн нь бодитой бус, нотолгоонд үндэслээгүй, гарсан алдаа, дутагдлыг засах арга замыг тодорхойлоогүй зэрэг нь хяналт-шалгалтын үр нөлөөг бууруулж байна.

**2.3.2 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон төлбөрийн нэхэмжлэлд
холбогдох стандарт, хууль журмын дагуу хяналт тавьж байна уу?**

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.5-д эрүүл мэндийн даатгалын байгууллага нь даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар болон зардлын төлбөрт хяналт тавьж, энэ хуулийн 14.8.7- д заасан журамд тусгагдсан чанарын шалгуур хангасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд төлбөр олгохоор заасан байна.

Эрүүл мэндийн салбарын үр дүн, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор эрүүл мэндийн даатгалын байгууллага нь тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгүүд, тэдгээрийн төлбөрийн хэмжээг тогтоож, эмнэлгүүдийн үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлийг хянаж, санхүүжүүлж байна.

Аймгийн ЭМДХ нь ЭМДҮЗ-ийн 2021 оны 05 дугаар тогтоолоор баталж, 2022 оны 12 дугаар тогтоолоор шинэчилсэн “Чанар, төлбөрийн хяналтын журам”,

ЭМДЕГ-ын даргын 2021 оны А/98 дугаар тушаалаар баталж, 2022 оны А/139 дүгээр тушаалаар шинэчилсэн “Нэхэмжлэлийн хяналтын журам”-ыг тус тус үндэслэн эрүүл мэндийн байгууллагуудын нэхэмжлэлийн хяналтыг хэрэгжүүлж байна.

Дээрх журмуудад заасны дагуу аймгийн ЭМДХ нь олон улсын эмнэл зүйн удирдамжид суурилсан чанарын шалгуурыг цахим хяналт, эмчийн хяналт, эх олонлогийн гэсэн 3 төрлөөр хослуулан худалдан авсан тусламж үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж байна.

Аймгийн хэмжээнд 2021-2022 онуудад гэрээгээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, ЭМДС-аас санхүүжсэн ЭМБ-уудын тоо, нэхэмжлэлийн дүн, гүйцэтгэлийг хянаж олгохоор тооцсон санхүүжилтийг хүснэгтээр харуулахад дараах байдалтай байна.

ЭМБ-уудын 2021-2022 оны гүйцэтгэлийн санхүүжилтийн нэхэмжлэлд чанар, төлбөрийн хяналтыг хэрэгжүүлж олгосон санхүүжилт

Хүснэгт 10

/сая төгрөгөөр/

д/д	ЭМБ төрөл	2021 он				2022 он				Өөрчлөлт		
		ЭМБ-ын тоо	Нэхэмжил-сэн	Хасагдсан	Олгосон	ЭМБ-ын тоо	Нэхэмжил-сэн	Хасагдсан	Олгосон	ЭМБ-ын тоо	Мөнгөн дүн	хувь
1	Улсын эмнэлэг	2	16,782.2	2,651.1	14,131.2	2	16,700.3	2,251.8	14,448.6	-	317.4	102.2
2	Хувийн эмнэлэг	6	1,722.6	102.4	1,620.2	6	1,958.0	101.7	1,856.2	-	236.0	114.6
3	Сум, тосгоны эрүүл мэндийн төв	21	5,395.8	239.2	5,156.6	21	13,152.8	390.6	12,762.2	-	7,605.6	247.5
4	Өрхийн эрүүл мэндийн төв	3	502.7	82.5	420.2	5	2,218.2	31.3	2,186.9	2	1,766.8	520.5
6	Лаборатори	1	4.2	-	4.2	-	-	-	-	(1)	(4.2)	-
7	Эмийн сан	42	1,943.3	17.3	1,926.0	39	2,194.0	42.5	2,151.5	(3)	225.5	111.7
	Нийт дүн	75	26,350.8	3,092.5	23,258.4	73	36,223.3	2,817.8	33,405.5	(2)	10,147.1	143.6

Эх сурвалж: ЭМДХ-ийн 2021-2022 онын хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан

Хүснэгтээс харахад:

- 2021 онд эрүүл мэндийн 75 байгууллага 26,350.8 сая төгрөгийн 444 гүйцэтгэлийн нэхэмжлэл ирүүлснээс худалдан авах, тусламж үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтаар 3,092.5 сая төгрөгийн хасалт хийсэн нь нийт нэхэмжлэлийн 11.7 хувийг эзэлж байна.
- 2022 онд эрүүл мэндийн 73 байгууллага 36,223.3 сая төгрөгийн 1390 нэхэмжлэл ирүүлснээс 2,817.8 сая төгрөгийн хасалт хийсэн нь нийт нэхэмжлэлийн 7.8 хувийг эзэлж байна.

Аймгийн ЭМДХ-ээс эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын шаардлага хангаагүй, нэхэмжлэлийн хяналтаар хасагдсан зардлын шалтгаан, алдаа, зөрчлийг олгох санхүүжилтийн дүн, зөвлөмжийн хамт эрүүл мэндийн байгууллагууд нэхэмжлэлийн хяналтыг дууссан тухай бүр албан бичгээр хүргүүлж байна.

Нэхэмжлэлийн хяналтын үр дүнд 2022 онд үзүүлсэн тусламж үйлчилгээний тоо өмнөх оноос 28.1 хувиар, санхүүжилтийн хэмжээ 10,147.1 сая төгрөгөөр нэмэгдэн, хяналтаар хасагдсан санхүүжилт 4 хувиар буурч, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж тодорхой хэмжээгээр нэмэгдэхэд эерэг нөлөө үзүүлж байна.

Бид аудитын явцад ЭМБ-уудын удирдлага, албан хаагчидтай чанар, төлбөрийн хяналтын журам болон нэхэмжлэлийг хянах журмын хэрэгжилтийн талаар асуулга, ярилцлага хийж, үнэлэлт дүгнэлт өгсний үндсэн дээр үүсэх хүндрэл бэрхшээлийг тодорхойлж, нэхэмжлэлийн хяналтыг дараах чиглэлээр зайлшгүй сайжруулах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- ✓ Эрчимт эмчилгээний улаан эрэмбийн А, яаралтай тусламжийн ногоон, шар эрэмбийн А зэрэглэлийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг төрөлжсөн эмнэлгүүдэд л олгохоор хязгаарласнаас амь нас тэмцсэн үед уг тусламж, үйлчилгээг үзүүлээд санхүүжилтээ нэхэмжлэх эрх үүсдэггүй, эсвэл санхүүжилтээ авахын тулд эрэмбэ бууруулж оношилбол өвчтөний биеийн байдлыг буруу үнэлсэн асуудалд орох эрсдэл үүсдэг,
- ✓ Нэхэмжлэхийн шалгуурт заасан бодит цагийн горим нь эмч, сувилагчийн ажлын ачаалалттай зохицохгүй байгаа тул бодит цагийн горимын хугацааг нэмэгдүүлэх /24 цагийг зарим тусламж үйлчилгээн дээр 48 цаг болгох /,
- ✓ Ehealth программд ЭМДХ-т нэхэмжлэлийг цахимаар илгээхийн өмнө болон хянагдсаны дараах үр дүнгүүдийг ЭМБ-д харагддаг болгохоор программын хөгжүүлэлтийг хийх,
- ✓ Тусламж үйлчилгээний чанарын хяналтын эмнэлзүйн шалгуураар 90 онооноос багаар үнэлэгдсэн тохиолдолд, санхүүжилтийг бүрэн хасалт хийх бус тухайн бодит гүйцэтгэлд тохирсон санхүүжилтийг олгодог байхаар өөрчлөлт хийх,
- ✓ ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоол нь сумын ЭМТ-д зарим шалгуур нь тохирдоггүй, анхан шатны шатлалд хийгддэггүй шинжилгээг шаардсан байдаг. Тухайлбал, архаг хууч өвчтэй хүмүүсийг хэвтүүлэхэд шаардсан шинжилгээг хийлгэж ирэхгүй байх тохиолдол их, үүнээс шалтгаалан тусламж үйлчилгээ үзүүлэхэд хүндрэл үүсдэг,
- ✓ ЭМДҮЗ-ийн 12 дугаар тогтоолоор батлагдсан олон улсын эмнэлзүйн зарим шалгуур нь бодит байдалтай нийцдэггүй, тухайлбал жирэмсний хяналт, эрт илрүүлгийн шалгуур гэх мэт.

2.3.3 Эрх бүхий этгээд хууль тогтоомж, журамд заасан хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж байна уу?

2021-2022 онуудад ЭМБ-дад эрх бүхий байгууллагуудаас хууль тогтоомж, журамд заасан дараах төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтууд хийгдсэн байна. Үүнд:

- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эм эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас Мандал сумын хувийн эмнэлэг болох Нямзул ХХК-ийн Нямзул дотор, эмэгтэйчүүдийн эмнэлэгт төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.
- Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэг болон Сүхбаатар сумын Эмнэх, Номт хан өрхийн эрүүл мэндийн төвүүдэд МХЕГ, Сэлэнгэ аймгийн МХГ-тай хамтран хийсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар эмчилгээний чанарын болон эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтыг хэрэгжүүлж илэрсэн зөрчил, дутагдлыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор арилгаж биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн байна.
- Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс аймгийн нэгдсэн эмнэлгийн 2022 оны гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хэрэгжилтийн тайлантай холбоотой зөрчил дутагдлыг арилгах зөвлөмж, үнэлгээ хүргүүлсэн байна.
- Аймгийн ЭМГ-аас төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт-шинжилгээ, үнэлгээ, 2021 онд /Баянгол, Орхонтуул, Баруунбүрэн, Сайхан, Түшиг, Цагааннуур, Хушаат, Жавхлант/ сумын ЭМТ-үүд, 2022 онд /Шаамар, Дулаанхан, Орхонтуул, Зүүнбүрэн, Хүдэр сумын ЭМТ-ийг хамруулан хийсэн байна.

Гэвч хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, дүгнээгүй бөгөөд дээрхээс бусад эрүүл мэндийн байгууллагуудад 2021-2022 онуудад огт хяналт, шалгалт хийгээгүй байгаа нь хяналт шалгалтын үр нөлөөг бууруулж байна.

Харин эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, түүний үр дүнд тусгайлсан хяналт шалгалт хийгдээгүй байна.

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулиудын хэрэгжилтийг хангаж нэгдсэн эмнэлгийн удирдлагыг ТУЗ, түүнээс сонгогдсон гүйцэтгэх удирдлагаар дамжуулан хэрэгжүүлэх тогтолцоонд шилжүүлэхээр ЭМЯ-аас 2021 онд 10 төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэгт ТУЗ байгуулахаар төлөвлөсөнд тус аймгийн нэгдсэн эмнэлэг багтсан байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйл, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлд ТУЗ-ийг 9 гишүүнтэйгээр байгуулах, гишүүнийг сонгох, түүнд тавигдах шалгуурыг тус тус заасны дагуу аймгийн Засаг даргын 2018 оны А/35 дугаар захирамжаар аймгийн нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийг анх байгуулж, 2020, 2021 онуудад шинэчлэн байгуулсан боловч ТУЗ-ийн бүрэлдэхүүний олон нийтийн төлөөллийн гишүүд нь холбогдох шаардлага хангаагүй, ашиг сонирхлын зөрчилтэй гэх үндэслэлээр гишүүдийн хооронд маргаан үүсэж, өнөөг хүртэл үйл ажиллагаа явуулаагүй байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн дагуу байгуулж, хэвийн,

тасралтгүй үйл ажиллагааг хангах арга хэмжээг аваагүй байгаа нь Эрүүл мэндийн салбарын шинэчлэл зөв, үр дүнтэй хэрэгжихгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

2.3.4 Эрүүл мэндийн даатгалын байгууллага, Шилэн дансны тухай болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөн ажиллаж байна уу?

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн даатгалын тасаг нь 2021 оны 1 дүгээр сараас ЭМДЕГ-ын Сэлэнгэ аймаг дахь ЭМДХ болон өргөжин 5 хүний орон тоотойгоор үйл ажиллагаа явуулахаар бүтэц орон тооны өөрчлөлт хийгдсэн боловч ЭМДЕГ-аас төсөв хөрөнгийн зарцуулалтыг нэгдсэн удирдлагаар ханган, гүйцэтгэж байна.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Аудитаар илэрсэн нийт **1,463.7** сая төгрөгийн зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх **албан шаардлага** хүргүүллээ. Үүнд:

- ЭМДЕГ нь 2022 онд эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүй,
- Өрх, сум тосгоны 26 анхан шатны эрүүл мэндийн байгууллагын 20 хувийн үлдэгдэл санхүүжилтийг сар бүр тогтмол олголгүйгээр ЭМДҮЗ-ийн 2022 оны 4 дүгээр тогтоолоор 4-6 сарын, 10 дугаар тогтоолоор 7-10 сарын санхүүжилт **783.0 сая** төгрөг, 2023 оны 01 дүгээр тогтоолоор 2022 оны 11, 12 дугаар сарын санхүүжилт **276.5** сая төгрөгийг 2023 оны 2 дугаар сард тус тус бөөнөөр нь олгосон,
- Аймгийн Засаг дарга нь ӨЭМТ-тэй байгуулсан гуравласан гэрээнд байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан боловч аймгийн төсөвт тусгаж батлаагүйгээс өрхийн ЭМТ-үүд нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтээс 2021 онд 14.3 сая төгрөг, 2022 онд 38.5 сая төгрөг буюу нийт **52.8** сая төгрөгийг тогтмол зардалд зарцуулсан,
- 2022 онд 12 сумын ЭМТ нь төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр бус төсвийн шууд захирагчийн шийдвэрээр албан хаагчдын цалинг 10-50 хувиар, нэмэгдүүлэн цалингийн зардлыг нийт **351.4 сая төгрөгөөр** нэмэгдүүлсэн
- Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн дагуу аймгийн нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийг зохион байгуулж, үйл ажиллагааг хэвшүүлээгүй.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоог хөгжлийн бодлогын барим бичгүүд, олон улсын жишгийн дагуу зохион байгуулсан хэдий ч цаашид засаж, сайжруулах шаардлагатай, хүндрэл бэрхшээлтэй асуудлууд оршиж байна.

1. 2022 оны инфляци 13.2 хувьд хүрч, Засгийн Газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ”-г шинэчлэн тогтоосон байхад эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний суурь тарифын хэмжээг шинэчлэн тогтоогүй байна.
2. ЭМДҮЗ-өөс аймгийн 2022 оны эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр хэт өндрөөр төлөвлөснөөс төлөвлөгөөг 26.2 хувиар тасалсан байна.
3. Аймгийн ЭМДХ нь эрүүл мэндийн байгууллагуудын нэхэмжлэхийг журмын дагуу хянаж, гүйцэтгэлийг эрүүл мэндийн байгууллагуудтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ЭМДЕГ-т үнэн зөв тайлагнасан байна.
4. Сонгон шалгаруулалтыг 3 жилд нэг удаа нэгдсэн журмаар зохион байгуулахаар зохицуулсан нь эрүүл мэндийн байгууллагууд журамд заасан тусгай шаардлага, шалгуурыг хангасан үедээ нэмэлт сонгон шалгаруулалтад орох, улмаар эмчилгээ үйлчилгээгээр өрсөлдөх боломжийг хязгаарлаж байна.
5. Эрүүл мэндийн байгууллагуудтай байгуулсан гэрээний гүйцэтгэлийг дүгнэх шалгуур үзүүлэлт нь тодорхой бус, дүгнэх аргачлал нь орон нутгийн онцлогт тохирохгүй байгаагаас шалтгаалан гэрээг бодитой үнэлж, дүгнэж чадахгүй байна.
6. ЭМДС-ийн санхүүжилтийг журамд заасан хугацаанд нь тухай бүр олгохгүй байгаа нь анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын хүн амд үзүүлэх анхан шатны цогц тусламж, үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй, тасралтгүй хүргэхэд санхүүгийн эх үүсвэр дутагдах эрсдэлийг үүсгэж байна.
7. Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь нөхөрлөлийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг гэх үндэслэлээр ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтоолт, хөрөнгө, санхүүжилтийн зарцуулалтад төрөөс хяналт шалгалт хийх хууль эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа нь ЭМДС-ийн санхүүжилтийн дийлэнх хувийг эмчилгээ, тусламж үйлчилгээнд бус ажилтнуудын цалин хангамжийг нэмэгдүүлэх болон бусад чиглэлээр зарцуулах сөрөг хандлагыг бий болгож байна.
8. Сум, тосгодын ЭМТ-ийн төсвийн шууд захирагчийн шийдвэрээр 2022 онд ажилтнуудын цалингийн доод жишгийг 10-50 хувиар нэмэгдүүлсэн байна.
9. “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-ний буюу урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилт хангалтгүйгээс 2022 онд ердийн өвчлөлөөс бус ахуйн осол, гэмтлээс шалтгаалсан өвчлөл, нас баралт тус тус хүрэх түвшнээс нэмэгдсэн байна.
10. Эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн ам, тэдгээрийг ЭМД-д хэрхэн хамруулах талаар тодорхойлсон бодит тооцоо судалгаа хийгдээгүй, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулаагүй байна.
11. Ашиглагч эрүүл мэндийн байгууллагуудын санал хүсэлтийг тухай бүр авсны үндсэн дээр эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд ашиглагдаж буй цахим системийн хөгжүүлэлтийг тухай бүр хийгээгүй байна.

12. Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан эрүүл мэндийн байгууллагуудын зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд баримт нотолгоонд үндэслэсэн, үр нөлөө бүхий хяналт шалгалт хийгдээгүй байна.
13. Аймгийн нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн дагуу байгуулж, хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах арга хэмжээ аваагүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж-д:

- Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хийх хяналт-шинжилгээ үнэлгээг бодит нотолгоонд үндэслэн гүйцэтгэж, гарсан үр дүн, үр нөлөөг тооцож байх.
- Эрүүл мэндийн даатгалын сангийн тогтолцооны аймгийн хэмжээний хэрэгжилтэд холбогдох байгууллагууд, албан тушаалтнуудыг оролцуулсан, байгууллага хоорондын уялдаа холбоог хангасан хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, өгсөн зөвлөмж, арга хэмжээний хэрэгжилтийг тооцож байх.

Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга Ц.Дэлгэрт:

- Аймгийн НДХ-тэй хамтран эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн тооцон, холбогдох байгууллагуудад санал хүргүүлж, үндэслэлтэй төлөвлүүлж, батлуулах арга хэмжээ авах.
- Эрүүл мэндийн байгууллагуудын гэрээ дүгнэх үзүүлэлтийг цахим санд бүрэн, үнэн зөв, мэдээлэх талаар холбогдох албан тушаалтнуудад сургалт, сурталчилгаа зохион байгуулж, гэрээ дүгнэх бэлтгэх ажлыг хангуулсны үндсэн дээр бодитоор дүгнэж байх.
- ЭМДС-ийн санхүүжилтийг журамд заасан хугацаанд нь тухай бүр олгох асуудлыг дээд шатны байгууллагад уламжлан шийдвэрлүүлж, эрүүл мэндийн байгууллагуудыг хэвийн, тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжоор хангах.
- Эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа иргэдийг ЭМД-д хэрхэн хамруулах талаар бодит тооцоо судалгаа хийж, даатгалд хамруулах замаар эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.
- Ашиглагч эрүүл мэндийн байгууллагуудын санал хүсэлтийг тухай бүр авч, дээд шатны байгууллагад уламжилсны үндсэн дээр эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд ашиглагдаж буй цахим системийн хөгжүүлэлтийг хийж байх.

Эрүүл мэндийн байгууллагын дарга нарт:

- Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийн хүрээнд тулгарч буй хүндрэл, бэрхшээл,

санал хүсэлтийг тухай бүр холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх.

- Эмчилгээ, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар ЭМДС-аас авах санхүүжилтийг нэмэгдүүлэх, олгосон санхүүжилтийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж байх.
- Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас нэхэмжилсэн санхүүжилтийг худалдан авах, тусламж үйлчилгээний чанар болон төлбөрийн хяналтаар хасалт хийлгэж буй шалтгааныг бодитоор тодорхойлж, арилгах замаар санхүүжилтийг бүрэн гүйцэт авч байх.
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх замаар өвчлөлийг бууруулах, эмчилгээ, үйлчилгээний зардлыг хэмнэх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Ц.ОТГОНБАЯР

Т.ОДСҮРЭН

Д.ЧУЛУУНЦЭЦЭГ

Б.НАРАНЦЭЦЭГ



**Эрүүл мэндийн даатгал, үрд дүнд суурилсан санхүүжилтийн
тогтолцоо, үр нөлөө**


Хавсралт 01

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ 2021 ОН

/Сая төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр		Төрийн өмчит лавлагаа шатны ЭМБ	Сум, тосгоны ЭМТ	Өрхийн ЭМТ	Хувийн хэвш- лийн ЭМБ	Ковид-19 вакцин	Ковид-19 сорьц авах	Эм ханган нийлүү- лэгч байгуул- лага	Дүн
1	1 иргэнээр тооцсон	Хүний тоо	-	-	-	-	-	-	-	-
		Мөнгөн дүн	-	-	-	-	-	-	-	-
2	Сэргээн засах үйлчилгээ	Хүний тоо	-	-	-	-	-	-	-	-
		Мөнгөн дүн	-	-	-	-	-	-	-	-
3	Гэрээр үзүүлэх тусламж	Хүний тоо	-	-	-	-	-	-	-	-
		Мөнгөн дүн	-	-	-	-	-	-	-	-
4	Өдрийн эмчилгээ	Хүний тоо	407.00	-	15,311.00	-	-	-	-	15,718.00
		Мөнгөн дүн	85.95	-	392.29	-	-	-	-	478.24
5	Өдрийн мэс засал	Хүний тоо	-	-	-	-	-	-	-	-
		Мөнгөн дүн	-	-	-	-	-	-	-	-
6	Оншилгоо шинжилгээ	Хүний тоо	7,243.00	-	-	-	-	-	-	7,243.00
		Мөнгөн дүн	255.94	-	-	-	-	-	-	255.94
7	Хэвтүүлэн эмчлэх тусламж	Хүний тоо	6,551.00	-	-	3,293.00	-	-	-	9,844.00
		Мөнгөн дүн	3,594.49	-	-	1,566.68	-	-	-	5,161.17
8	Амбулаторын тусламж	Хүний тоо	98,910.00	-	-	-	-	-	-	98,910.00
		Мөнгөн дүн	2,581.64	-	-	-	-	-	-	2,581.64
9	Өндөр өртөгтэй оношилгоо	Хүний тоо	683.00	-	-	-	-	-	-	683.00
		Мөнгөн дүн	42.43	-	-	-	-	-	-	42.43
10	Яаралтай тусламж	Хүний тоо	5,180.00	-	-	-	-	-	-	5,180.00
		Мөнгөн дүн	485.00	-	-	-	-	-	-	485.00
11	Түргэн тусламж	Хүний тоо	4,502.00	-	-	-	-	-	-	4,502.00
		Мөнгөн дүн	168.56	-	-	-	-	-	-	168.56
12	Гемодиализ	Хүний тоо	3,273.00	-	-	-	-	-	-	3,273.00
		Мөнгөн дүн	320.76	-	-	-	-	-	-	320.76
13	Шуурхай тусламж үйлчилгээ	Хүний тоо	-	-	-	-	-	-	-	-
		Мөнгөн дүн	-	-	-	-	-	-	-	-
14	Хөнгөвчлөх тусламж	Хүний тоо	29.00	-	-	-	-	-	-	29.00
		Мөнгөн дүн	14.15	-	-	-	-	-	-	14.15
15	Уламжлалтын тусламж	Хүний тоо	359.00	-	-	127.00	-	-	-	486.00
		Мөнгөн дүн	102.34	-	-	53.53	-	-	-	155.87
16	Төр хариуцах эм	Хүний тоо	1,898.00	-	-	-	-	-	-	1,898.00
		Мөнгөн дүн	65.78	-	-	-	-	-	-	65.78
17	Ковид /хэвтэн/	Хүний тоо	7,450.00	-	-	-	-	-	-	7,450.00
		Мөнгөн дүн	8,553.52	-	-	-	-	-	-	8,553.52
18	Ковид -19	Хүний тоо	-	-	8,552.00	-	122,328.00	35,454.00	-	166,334.00
		Мөнгөн дүн	-	-	1,357.61	-	611.64	1,058.91	-	3,028.16
19	ЭМДС-аас санхүүжих эмийн	Хүний тоо	1,107.00	-	-	-	-	-	66,442.00	67,549.00
		Мөнгөн дүн	70.01	-	-	-	-	-	1,855.99	1,926.00
20	Урьдчилан сэргийлэх үзлэг	Хүний тоо	747.00	-	-	-	-	-	-	747.00
		Мөнгөн дүн	21.17	-	-	-	-	-	-	21.17
Нийт санхүүжилт		Хүний тоо	138,339.00	-	23,863.00	3,420.00	122,328.00	35,454.00	66,442.00	389,846.00
		Мөнгөн дүн	16,361.73	-	1,749.90	1,620.21	611.64	1,058.91	1,855.99	23,258.38

**Эрүүл мэндийн даатгал, үрд дүнд суурилсан санхүүжилтийн
тогтолцоо, үр нөлөө**



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОСОН САНХҮҮЖИЛТ 2022 ОН

/Сая төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Төрийн өмчит лавлагаа шатны ЭМБ	Сум, тосгоны ЭМТ	Өрхийн ЭМТ	Хувийн хэвшлийн ЭМБ	Ковид-19 вакцин	Ковид-19 сорьц авах	Эм ханган нийлүү- лэгч байгуул- лага	Дүн
1	1 иргэнээр тооцсон	Хүний тоо	-	66,156.00	42,400.00	-	-	-	108,556.00
		Мөнгөн дүн	-	6,745.50	1,923.47	-	-	-	8,668.97
2	Сэргээн засах үйлчилгээ	Хүний тоо	11.00	2,797.00	185.00	-	-	-	2,993.00
		Мөнгөн дүн	0.12	139.61	9.84	-	-	-	149.57
3	Гэрээр үзүүлэх тусламж	Хүний тоо	-	805.00	62.00	-	-	-	867.00
		Мөнгөн дүн	-	46.24	4.16	-	-	-	50.40
4	Өдрийн эмчилгээ	Хүний тоо	1,103.00	2,245.00	120.00	-	-	-	3,468.00
		Мөнгөн дүн	264.62	179.70	11.79	-	-	-	456.11
5	Өдрийн мэс засал	Хүний тоо	1.00	-	-	-	-	-	1.00
		Мөнгөн дүн	0.41	-	-	-	-	-	0.41
6	Оншилгоо шинжилгээ	Хүний тоо	-	15,894.00	-	-	-	-	15,894.00
		Мөнгөн дүн	-	236.40	-	-	-	-	236.40
7	Хэвтүүлэн эмчлэх тусламж	Хүний тоо	9,475.00	4,679.00	-	3,348.00	-	-	17,502.00
		Мөнгөн дүн	5,739.20	3,120.04	-	1,592.06	-	-	10,451.30
8	Амбулаторын тусламж	Хүний тоо	133,767.00	-	-	-	-	-	133,767.00
		Мөнгөн дүн	3,846.24	-	-	-	-	-	3,846.24
9	Өндөр өртөгтэй оношилгоо,	Хүний тоо	2,737.00	-	-	-	-	-	2,737.00
		Мөнгөн дүн	242.57	-	-	-	-	-	242.57
10	Яаралтай тусламж,	Хүний тоо	12,115.00	2,270.00	-	-	-	-	14,385.00
		Мөнгөн дүн	1,292.11	120.85	-	-	-	-	1,412.96
11	Түргэн тусламж	Хүний тоо	6,949.00	13,562.00	-	-	-	-	20,511.00
		Мөнгөн дүн	336.96	741.02	-	-	-	-	1,077.98
12	Гемодиализ	Хүний тоо	3,208.00	-	-	-	-	-	3,208.00
		Мөнгөн дүн	461.91	-	-	-	-	-	461.91
13	Шуурхай тусламж үйлчилгээ	Хүний тоо	-	1,016.00	-	-	-	-	1,016.00
		Мөнгөн дүн	-	48.67	-	-	-	-	48.67
14	Хөнгөвчлөх тусламж,	Хүний тоо	80.00	-	-	-	-	-	80.00
		Мөнгөн дүн	62.95	-	-	-	-	-	62.95
15	Уламжлалтын тусламж	Хүний тоо	5,736.00	-	-	495.00	-	-	6,231.00
		Мөнгөн дүн	624.21	-	-	264.18	-	-	888.39
16	Төр хариуцах эм	Хүний тоо	56,075.00	-	-	-	-	-	56,075.00
		Мөнгөн дүн	72.24	-	-	-	-	-	72.24
17	Ковид амбулатори	Хүний тоо	33.00	-	-	-	-	-	33.00
		Мөнгөн дүн	0.66	-	-	-	-	-	0.66
18	Ковид -19	Хүний тоо	983.00	-	7,033.00	-	16,074.00	14,656.00	38,746.00
		Мөнгөн дүн	1,371.60	-	1,125.28	-	80.37	419.24	2,996.49
19	ЭМДС-аас санхүүжих эмийн	Хүний тоо	-	-	-	-	-	70,521.00	70,521.00
		Мөнгөн дүн	-	-	-	-	-	2,151.52	2,151.52
20	Урьдчилан сэргийлэх үзлэг	Хүний тоо	2,812.00	-	-	-	-	-	2,812.00
		Мөнгөн дүн	129.76	-	-	-	-	-	129.76
Нийт санхүүжилт		Хүний тоо	235,085.00	109,424.00	49,800.00	3,843.00	16,074.00	14,656.00	499,403.00
		Мөнгөн дүн	14,445.57	11,378.03	3,074.54	1,856.24	80.37	419.24	33,405.52

Хавсралт 03

/сая төгрөгөөр/

ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2022 ОНД АВСАН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТЫН СУДАЛГАА

№	Байгууллагын нэр	Оны эхний дансны үлдэгдэл	Нийт орлого, эх үүсвэр	Орлогын төрөл						Нийт зарцуулалт	Цалин	НДШ	Тогтмол зардал
				Нэг иргэнээр тооцсон санхүүжилт	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний орлого	Урьдчилан сэргийлэх /лаборатори/	Бусад орлого	7	8	9	10		
1	Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлэг	77.91	10,842.19	-	7,527.52	88.31	3,226.36	10,909.72	5,627.02	695.55	1,010.04		
2	Мандал сумын Нэгдсэн эмнэлэг	2.54	6,363.96	-	5,416.20	54.87	892.90	6,364.75	3,472.43	438.66	583.07		
	ДҮН	80.45	17,206.16	-	12,943.72	143.18	4,119.26	17,274.47	9,099.46	1,134.21	1,593.10		
1	Алтанбулаг СЭМТ	0	833.95	399.65	265.25	-	169.05	824.52	429.46	48.42	35.54		
2	Баруунбүрэн СЭМТ	0	645.30	358.47	200.61	-	86.22	517.16	271.08	34.45	23.69		
3	Баянгол СЭМТ	0	1,326.01	438.50	336.03	-	551.48	1,121.47	525.62	63.77	40.47		
4	Бугант СЭМТ	0	774.48	317.25	219.24	-	237.99	703.45	313.35	36.23	70.66		
5	Дулаанхаан СЭМТ	0	1,082.72	216.08	146.28	-	720.36	1,088.85	295.43	38.19	45.67		
6	Ерөө СЭМТ	0	1,042.00	343.31	259.24	-	439.44	941.55	412.06	50.46	86.63		
7	Жавхлант СЭМТ	0	611.26	239.08	189.55	-	182.64	600.93	309.70	37.99	33.10		
8	Зүүнбүрэн СЭМТ	0	484.30	274.78	145.30	-	64.23	429.45	233.65	28.64	21.51		
9	Номгон СЭМТ /Сайхан/	0	570.74	257.93	211.89	-	100.92	465.48	278.04	34.72	25.57		
10	Орхон СЭМТ	0	527.59	276.60	138.26	-	112.73	486.90	283.09	36.62	41.10		
11	Орхонтул СЭМТ	0	499.14	238.43	103.24	-	157.47	418.01	218.13	28.07	37.68		
12	Рашаант ТЭМТ /Орхонтул/	0	598.42	246.81	171.59	-	180.01	536.24	266.17	33.36	26.73		
13	Сайхан СЭМТ	0	2,384.52	634.11	728.74	-	1,021.67	2,094.30	997.02	129.66	226.32		
14	Сант СЭМТ	0	529.35	274.47	129.02	-	125.86	490.28	254.29	31.25	14.84		
15	Түнхэл ТЭМТ /Мандал/	0	794.11	402.76	267.63	-	123.72	779.05	420.41	47.72	31.31		
16	Түшиг СЭМТ	0	482.95	241.48	111.13	-	130.34	447.15	238.77	30.09	22.63		
17	Хушаат СЭМТ	0	455.79	239.23	106.39	-	110.17	439.58	239.80	30.06	27.92		
18	Хүдэр СЭМТ	0	623.36	304.84	185.55	-	132.97	595.51	315.70	39.34	29.70		
19	Хэрх ТЭМТ /Мандал/	0	956.66	366.63	254.24	-	335.79	909.21	451.30	34.84	50.85		
20	Цагааннуур СЭМТ	0	889.73	435.27	302.71	0.15	151.60	834.89	465.82	58.22	32.00		
21	Шаамар СЭМТ	0	600.38	239.81	160.64	-	199.92	564.60	301.78	32.29	38.90		
	ДҮН	-	16,712.77	6,745.50	4,632.53	0.15	5,334.58	15,268.58	7,520.64	904.39	962.80		
1	Ачит амьдраллагч ЭЭМТ	0.01	365.65	245.56	10.85	-	109.24	357.87	222.67	25.21	2.30		
2	Номт хан ЭЭМТ	0	902.61	583.98	6.84	-	311.78	890.54	568.58	68.64	13.81		
3	Үйлст эмнэхүй ЭЭМТ	0.02	429.50	290.28	2.46	-	136.76	421.09	239.53	28.89	5.75		
4	Хараа манал ЭЭМТ	0.02	488.34	354.65	2.62	-	131.07	452.24	272.19	34.43	6.27		
5	Эмнэх баг ЭЭМТ	0	688.91	449.00	3.02	-	236.89	682.17	426.48	49.56	9.39		
	ДҮН	0.05	2,875.01	1,923.47	25.79	-	925.75	2,803.91	1,729.45	206.74	37.51		
	НИЙТ ДҮН	80.50	36,793.94	8,668.97	17,602.04	143.33	10,379.60	35,346.97	18,349.55	2,245.34	2,593.41		

Хангамж- ийн материал	Зардлын төрөл							Оны эцсийн дансны үлдэгдэл		
	Нормативт зардал	Эд хогшил, урсгал засвар	Дотоод албан томилголт	Бусдаар гүйцэтгүүл- сэн бусад нийтлэг ажил	Бараа ажил үйлчилгээ- ний бусад зардал	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	Биет болон биет бус хөрөнгө худалдан авсан	18	19	
11	12	13	14	15	16	17	18	19		
192.51	3,160.30	70.47	14.99	61.46	16.40	18.16	42.81	10.38		
109.04	1,520.87	57.08	6.48	134.07	1.96	3.01	38.08	1.75		
301.55	4,681.17	127.55	21.47	195.53	18.36	21.17	80.89	12.13		
35.53	178.89	51.82	0.85	10.59	28.14	-	5.28	9.44		
42.76	110.80	13.56	0.37	3.88	9.80	-	6.78	128.14		
43.14	329.89	48.30	2.49	6.19	18.00	11.75	31.84	204.54		
31.83	109.26	13.95	0.79	0.59	13.02	-	113.77	71.03		
14.35	148.97	9.51	0.93	7.81	467.71	21.87	18.42	13.87		
33.00	278.58	21.59	0.89	2.54	7.34	-	48.45	100.45		
40.34	127.90	34.56	0.50	8.46	1.69	3.39	3.30	10.34		
19.43	80.10	20.06	0.41	-	21.53	-	4.11	54.85		
19.07	87.48	7.40	1.41	1.37	3.04	-	7.40	105.26		
19.67	77.67	16.19	1.69	1.62	5.70	-	3.55	40.69		
13.89	101.23	6.64	0.62	0.23	4.79	-	6.73	81.13		
22.68	140.05	4.58	2.55	16.48	5.84	-	17.80	62.18		
41.40	231.32	102.38	2.70	58.55	10.86	-	294.10	290.22		
26.83	130.72	7.97	1.25	1.01	11.88	2.80	7.45	38.07		
48.99	134.14	18.69	2.02	14.82	22.95	-	37.99	15.06		
20.95	100.02	3.56	1.20	0.24	2.62	-	27.06	35.81		
19.73	92.13	9.02	1.99	0.89	9.46	-	8.58	16.21		
43.44	122.81	16.79	1.65	11.11	10.63	-	4.33	27.86		
30.91	151.43	2.21	1.50	14.38	23.34	-	148.47	47.44		
54.31	97.30	70.46	1.70	11.99	22.33	0.20	20.55	54.83		
22.43	119.57	31.37	0.36	1.24	6.86	-	9.81	35.77		
644.66	2,950.27	510.63	27.88	173.98	707.54	40.00	825.79	1,444.18		
16.15	41.22	35.55	4.50	3.47	2.45	4.35	-	7.80		
23.03	155.24	27.82	0.66	4.72	-	5.51	22.52	12.06		
25.26	79.18	26.13	4.54	3.73	2.28	5.80	-	8.43		
20.18	60.71	43.63	3.98	2.22	2.84	5.79	-	36.12		
28.51	126.86	13.01	0.66	3.26	-	22.36	2.07	6.74		
113.13	463.22	146.14	14.34	17.41	7.57	43.81	24.59	71.15		
1,059.34	8,094.66	784.32	63.69	386.93	733.47	104.99	931.27	1,527.47		

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

Нэгдсэн эмнэлгийн байр-1, Сүхбаатар сум
Сэлэнгэ аймаг, 43085; Утас/Факс: (976) 7036-3586
Цахим шуудан: selenge.emg2@gmail.com
Цахим хуудас: www.emg.se.gov.mn

2023.05.19 № 450
танай 2023.05.18 -ны № 51 -т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Хариу хүргүүлэх тухай

“Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдэвт тайлангийн төсөлд санал байхгүй болно.

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ДЭЛГЭРЦЭЦЭГ





ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ЭРҮҮЛ
МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

43080, Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Утас/Факс: (976) 7036-3808, И-мэйл: selenge@emd.gov.mn
Вэбсайт: www.emd.gov.mn

2023.05.19 № 2765
танай 2023.05.18 -ны № 49 -Т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА ТАНАА

"Эрүүл мэндийн даатгал, үрд дүнд суурилсан
санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө" сэдэвт
гүйцэтгэлийн аудитын тайлангаар танилцлаа.
Тайлангийн дүгнэлт, зөвлөмжийг хүлээн зөвшөөрч
байна, хүргүүлэх санал үгүй болно.

ДАРГА Ц.ДЭЛГЭР



432100012



СЭЛЭНГЭ АЙМАГ
МАНДАЛ СУМЫН НЭГДСЭН
ЭМНЭЛЭГ

213212 Мандал сум, Сэлэнгэ аймаг,
Утас: 7036-7220
E-mail: mandal_sel@yahoo.com

2023.05.19 № 116
танай 2023.05.18 -ны № 49 -Т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ

"Эрүүл мэндийн даатгал, үрд дүнд суурилсан
санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө" сэдэвт
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.
Хүргүүлэх санал үгүй болно.

Хүндэтгэсэн

ДАРГА Б.ОУЯНДЭЛГЭР



СЭЛЭНГЭ АЙМАГ САЙХАН СУМЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Сэлэнгэ аймаг, Сайхан сум, Хөтөл
Утас: 70368381, И-мэйл хаяг: hutul_sel@yahoo.com,
saikhan.hospital@selenge.gov.mn

2023.05.19 № 41
танай 2023.05.18 -ны № 49 -Т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

"Эрүүл мэндийн даатгал, үрд дүнд суурилсан
санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө" сэдэвт
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа.

Уг төсөлд нэмж оруулах болон хасах саналгүй
болно.

ДАРГА Н.МОНХТУНГАЛАГ



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТАЙЛБАР

Тайлангийн төсөлд холбогдох байгууллагуудаас тайлбар санал ирүүлээгүй тул тайланд өөрчлөлт оруулахгүйгээр шийдвэрлэв.



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 19 өдөр


Дугаар 109

Сүхбаатар сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө”-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг УАГ-ын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар болон аймгийн ИТХ-ын дарга (Б.Нарантуяа), Засаг дарга (Н.Лхагвадорж), Эрүүл мэндийн газрын дарга (Ж.Од), Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга (Ц.Дэлгэр), Эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ, авч биелэлтийг тогтоосон хугацааны дотор ирүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөсүгэй.
4. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг аудитын баг (ахлах аудитор Ц.Отгонбаяр)-т үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Б.Батмөнх)-т даалгасугай.



Ч.ЭНХТУЯА

018010026
C:\Users\Bichig hereg\Tushaal 2023.docx